



МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

(Танилцуулга, үзэл баримтлал, төсөл, дагалдан гарах бусад хууль,
тогтоолын төсөл)

2020 он

Эмхэтгэлийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр хэвлэв.

“Хөх Монгол принтинг” ХХК-д хэвлэв.

АГУУЛГА

1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нутгийн удирдлагатай холбоотой нэмэлт, өөрчлөлт	5
2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга	10
3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал	16
4. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөл	22
5. Дагалдан гарах бусад хууль, тогтоолын төсөл	57
5.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг /шинэчилсэн найруулга/ хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай	58
5.2. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	59
5.3. Монгол Улсын татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	61
5.4. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	62
5.5. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	63



1 МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ



ХАРИУЦЛАГА



ХЯНАЛТ - ТЭНЦЭЛ



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН ҮНДСИЙГ ТОДОРХОЙ БОЛГОХ

57.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.



Хот, тосгон өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, **бие даан хөгжих, төрийн үйлчилгээ иргэдэд ойртох** боломж бүрдэнэ.

Хотууд улсын болон орон нутгийн зэрэглэлтэйгээр хөгжих болно.



Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлснээр орон нутгийн түвшинд **төрийн болон өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх хэмжээний давхардал** арилна.



ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙГ ӨӨРЧЛӨХ ЖУРАМ

57.3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.



Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх эсэх асуудлыг тухайн нутгийн **иргэдийн саналд үндэслэн** шийдвэрлэх зарчмыг хэвээр хадгална.

Монгол Улсад засаг, захиргааны шинэтгэл хийх эрх зүйн үндэс бүрдэнэ.

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

59.2. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно.

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

ХУУЛИАР ТОГТООСОН ХЯЗГААРЫН ХҮРЭЭНД

1. ӨМЧИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ



Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, **татварын хувь хэмжээг тогтоох эрх эдэлж, эдийн засгийн төвлөрөл багасч** улмаар орон нутгийн эдийн засгийн харьцангуй бие даасан байдал нэмэгдэх болно.

2. ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ ТОГТООХ



Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогоос хамаарч тэдгээрийн өмч болон **төсвийн харилцааг ялгамжтай зохицуулах боломж бүрдэнэ.**

2 ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА



МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулиар зохицуулагдах, суурь зарчим нь тодорхойлогдох харилцаа бол засаг захиргааны зохион байгуулалт, тухайн нэгж дэх удирдлагын асуудал юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлгээр уг харилцааг зохицуулах суурь үндсийг тодорхойлдог.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн төрийн байгууламжийн талаарх суурь үзэл санаа, Дөрөвдүгээр бүлэг, мөн түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн батлах үндэслэл болно.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдох арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсан. Уг тогтоолд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиудтай цогц байдлаар хамтад нь батлахаар нэр зааж орсныг дурдах нь зүйтэй.

1992 оноос хойш тухайн харилцааг зохицуулсан 2 удаагийн хууль (1992 оны болон өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2006 оны хууль) батлагдаж үйлчилж ирсэн байна. Дээрх хуулиудаар төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үе, мөн зах зээлийн эдийн засгийн харилцаанд ажиллаж чадахуйц нутгийн удирдлагын үйл ажиллагааны зарчим, арга, хэлбэрийг тодорхойлж байсан боловч Үндсэн хуулийн суурь үзэл санаа, зүйл, заалтыг гүнзгийрүүлж баяжуулах, нийгмийн харилцаанд шинээр бий болж буй арга, хэлбэрийг хүлээн зөвшөөрөх, зохицуулах зэрэг асуудлаар “хоцрогдож” ирсэн талаар төрөл бүрийн судалгаа, практик ажилтнуудын санал зөвлөмж гарсаар байна.

Ийнхүү Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсрууллаа. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Нийтлэг үндэслэл, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүү, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг

хот, тосгонд шилжүүлэх, Нэгжийн удирдлага бусад байгууллагатай харилцах, болон бусад гэсэн 6 бүлэг, Орон нутгийн чиг үүрэг, Нутгийн өөрийн удирдлага, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх төрийн удирдлага гэсэн 3 дэд бүлэг, 81 зүйлээс бүрдэнэ.

Үзэл баримтлалын нэг дэх хэсэгт дурдсанчлан уг хууль нь органик хууль (үндсэн хуулийг гүнзгийрүүлэн зохицуулсан хууль)-д хамаарах тул Үндсэн хуулийн үзэл санаа, зүйл, заалтыг гүнзгийрүүлэх, түүнд орсон нэр томьёог хэрэглэх, тодруулбал Үндсэн хуульд нийцүүлэх арга хэмжээг авна.

1. Хуулиар зохицуулагдах эхний бүлэг харилцаа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эрх зүйн байдал, засаг захиргааны хуваарь, тэдгээртэй холбогдох зохицуулалтууд:

1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш аймаг, сум, баг, мөн нийслэл, дүүрэг, хорооны чиг үүргийг хуулиар тусгайлан тодорхойлох, нэгж тус бүрийн чиг үүргийг зааглаж ялгаагүйгээс улбаалж дээр дурдсан нэгжүүдийн чиг үүрэг өөр хоорондоо холилдох, давхцах эсхүл хийдэл үүсэх, нэгжийн удирдлагын “ажил үүрэг”-ийг хуваарилахад ойлгомжгүй байдал үүсэх зэрэг сөрөг үр дагаварыг дагуулж ирэв. Энэ байдлыг залруулах зорилгоор нэгжүүдийн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлно:

- Иргэдэд хамгийн ойр нэгж болох баг, хорооны эрх зүйн байдлыг тодорхой болгох, энэ хүрээнд баг, хороо эрх зүйн харилцаанд оролцох эрх зүйн үндсийг бий болгох, баг хороонд нутгийн өөрийн удирдлагын бусад хэлбэрийг хэрэгжүүлэх, Үндсэн хуульд заасан зарчмын хүрээнд өдөр тутмынхаа тулгамдсан асуудлыг өөрсдөө бие дааж шийдвэрлэх, шийдвэрийн үр нөлөө, хүчин чадлыг дээшлүүлэх;
- Сум дүүрэг нь орон нутгийн өөрийн удирдлагын бие даасан цөм (суурь) нэгж байж, иргэдийн амьдралын тулгамдсан асуудлууд, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн зорилтыг шийдвэрлэх чиг үүрэг, бүрэн эрхтэй байх, үүнтэй холбоотойгоор энэ хуулиар бий болох орон нутгийн чиг үүргийг голлон хэрэгжүүлэх нэгж нь байх зэргээр нутгийн өөрийн удирдлагыг иргэдэд илүү ойр нэгжид төвлөрүүлэх;
- Аймаг нь сумдын нийтлэг эрх ашгийн төлөөлөл болохын зэрэгцээ төв засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, сум хоорондын асуудлыг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих чиглэл давамгайлсан чиг үүрэгтэй нэгж байхаар тодорхойлов. Энэ нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл Монгол Улсын хувьд чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх зарчим, журмыг шинээр зохицуулна. Үүнтэй уялдаатайгаар нэгж байгуулахад харгалзах үзүүлэлтүүдийг шинээр тодорхойлж, нэгжийг өөрчлөх асуудлыг нэг бүрчлэн шийдвэрлэх зохицуулалтыг бий болгоно. Нэгжийг өөрчлөх асуудлыг голлон боловсруулж, зохион байгуулах байгууллага нь Засгийн газар байна. Харин иргэдээс саналыг нь авах ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулах үүрэг хүлээх бөгөөд санал авах, үр дүнг тооцох журмыг Улсын Их Хурал тогтооно. Нэгжийг өөрчлөх асуудлаар иргэд санал тавих, Засгийн газар санаачлах үндэслэлийг хуулиар тодорхойлно.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоныг өөрийн удирдлагын хүрээнд эдийн засаг, нийгэм, аж ахуйн асуудлыг түлхүү шийдвэрлэх орон нутгийн корпораци хэлбэрт шилжих эрх зүйн үндэс бий болгохтой холбогдуулан хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, (аймаг, сум, баг, дүүрэг, хороо) түүний удирдлагын “Засаг захиргааны

шинжтэй” зарим чиг үүргийг хэрхэн яаж шилжүүлэх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага өөрийн нутаг дэвсгэр дэх хот, тосгоны өөрийн удирдлагатай харилцах суурь зарчмыг энэ хуулиар тогтооно.

3. Үндсэн хуулийн үзэл санааны дагуу нутгийн удирдлагыг хөгжүүлэх, бэхжүүлэх асуудал бол энэ хуулийн амин чухал асуудлын нэг байна.

- Эл хүрээнд юуны өмнө авах арга хэмжээ нь орон нутгийн чиг үүргийг тодорхойлох (ийм төрлийн чиг үүргийг орон нутгийн Хурал бие даан шийдвэрлэх бөгөөд төрөөс үүнд оролцохгүй), мөн түүнчлэн төрөөс орон нутгийн удирдлагад шилжүүлж болох болон шилжүүлж үл болох чиг үүргийн жагсаалтыг хуулиар тодорхойлно. Ингэхдээ чиг үүргийг аль болох иргэдэд ойр нэгжид хуваарилан, санхүүжилтийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх зарчмыг баримтална. Нутгийн өөрөө удирдах байгууллага орон нутгийн чиг үүргийг болон төрөөс шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ба эдгээрийн биелэлтэд төв Засгийн газар засаг төрийн төлөөлөгчөөрөө дамжуулан хяналт тавина.
- Орон нутгийн бие даасан байдлыг хангах хүрээнд өөрийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор иргэдийн шууд удирдлагын хэлбэр болох иргэдийн нийтийн Хурлын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг тусгайлан зохицуулахын сацуугаар бусад хэлбэр (иргэдийн санаачлах эрх, орон нутгийн санал асуулга зэрэг)-ийг хуульчилна.
- Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгчийн эрх зүйн байдлыг дэлгэрүүлж, төлөөлөгч ба сонгогч иргэний хооронд “амьд харилцаа” байх нөхцлийг бүрдүүлэх заалтуудыг хуулийн төсөлд оруулна. Үүнд: Төлөөлөгч иргэддээ тайлагнах, тэдний захиа даалгаврыг биелүүлэх, төлөөлж буй иргэдийн нэрийн өмнөөс гүйцэтгэх байгууллагатай харилцах (Засаг даргыг хянах, санал асуулга тавих гэх мэт) зэрэг өргөн эрх мэдэл, үүргийг төлөөлөгчид ногдуулна. Мөн нөгөө талаас үүргээ биелүүлэхгүй байгаа төлөөлөгчид хүлээлгэх хариуцлагыг шат дараатайгаар авахаар нарийвчлан зохицуулна.

Иргэдийн Төлөөлөгчийн Хурал хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чиг үүргээ биелүүлэхгүй байх, иргэд олон түмний итгэлийг хөсөрдүүлэх, бүлэглэх, улс төржих явдал цөөнгүй гарсан бөгөөд ийм байдлыг цаашид гаргуулахгүй байх зорилгоор төв засгийн хяналтыг тодруулж Хурлыг аймаг, нийслэлийн Засаг даргын санал оруулснаар Засгийн газар тараах шийдвэр гаргах зэрэг арга хэмжээ авах эрхтэй байхаар хуульчилна. Энэ хуулийн төслийн хүрээнд төв Засгийн газрын бодлого болон орон нутгийн ашиг сонирхол өөр байгаа тохиолдолд төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улсын хувьд Үндсэн хууль, бусад хуулийн хүрээнд асуудлыг хэрхэн шийдвэрлэж байх хуулийн механизмуудыг шинээр тодорхойлно.

- Нэгдмэл улсын хувьд төв Засгийн газраас нутгийн өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих нь зүй ёсны хэрэг боловч ингэснээр нутгийн өөрийн удирдлагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болохгүй. Иймээс нутгийн өөрийн удирдлагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах Үндсэн хуулийн механизмыг бүрдүүлэх талаар зохицуулалт энэ хуульд шинээр тусгана. Гадаад орнуудын жишиг мөн адил ийм байна.
- Сүүлийн жилүүдийн судалгаанд иргэдийн зүгээс байнга гаргадаг, зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудал нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг улс төрөөс ангид байлгах асуудал юм. Энэ зорилгоор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаагаа намын бүлгээр бус, байнгын болон түр хороо, ажлын хэсэг зэрэг өөрийн дотоод зохион байгуулалтын бүтэц,

арга хэлбэрээр явуулах зохицуулалтыг оруулна. Сумын Хуралын сонгуульд улс төрийн нам нэр дэвшүүлэхгүй байх, мөн бусад хурлын хувьд нэр дэвшүүлсэн нам нь төлөөлөгчөөр сонгогдсон гишүүндээ үүрэг хүлээлгэхгүй байхаар зохицуулна.

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын байгууллагыг адилтгах бус түүний чиг үүрэг, суурийн газрын онцлогт нийцүүлэн түүнийг сонгож байгуулах арга журмыг Үндсэн хуулийн суурь зарчимд нийцүүлэн тогтооно. Ингэхдээ аймаг, сум, дүүргийн хувьд тухайн орон нутагт байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох, харин нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас сонгож байгуулахаар зохицуулна.
4. Орон нутгийг бие даалгах, эдийн засаг, нийгмийн асуудлаа шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн цогцолбор болоход түүний эдийн засаг, санхүүгийн үндэс голлох үүрэгтэй билээ. Энэ чиглэлээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд энэ хууль, мөн төсвийн тухай төрийн болон орон нутгийн өмчийн тухай зэрэг хуулиудаар гүнзгийрүүлэн зохицуулна.
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжийн орлогын албан татварын тодорхой хувийг тухайн нэгжид хуулиар хуваарилах зарчмыг энэ хуульд тусгана. Татварын ерөнхий хуулийн 7.2.15-д заасан татварын орлогыг орон нутагт бүрэн үлдээх.
 - Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж орон нутгийн төсвийн төслийг боловсруулах, төсвөө бие даан батлах, төрөөс олгох татаас, тусгай зориулалтын шилжүүлгийг тухайн нэгж тус бүрт нэр заан батлах зарчмыг баталгаажуулах.
 - Орон нутгийн төсвийн төлөвлөлт нь улсын болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцсэн байх шаардлагыг тусгах.
 - Орон нутгийн санг бүрдүүлэхэд орон нутгийн санаачилга, оролцоог нэмэгдүүлж урамшуулах зохицуулалтыг бий болгох.
 - Орон нутгийн өмч үүсэх эрх зүйн үндсийг тодорхой болгох, орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчим, орон нутаг дахь төрийн өмчийн удирдлагыг хуулиар тодорхойлсон хязгаарын хүрээнд хэрэгжүүлэх журам. Орон нутгийн өмчид тавих хяналтыг тодорхой болгох.

Энэ талаар Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд ерөнхий суурь зарчмыг заах ба дээр дурдсан хуулиудаар нарийвчилсан зохицуулалтыг хийнэ.

5. Үндсэн хуулийн 59.2-т заасан нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын онцлогт нийцүүлэн хуулиар тогтоох үндэслэл, журмыг энэ хуулиар дэлгэрүүлэн зохицуулна.
6. Улсын Их Хурал бусад хуулийг батлахдаа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн суурь зарчимд нийцүүлэх чиглэл баримтална.
7. Орон нутгийн Хурал, Засаг даргын бүрэн эрхийг тодорхойлохдоо энэ хуулиар аль болох ерөнхийлөн заах (суурь зарчмыг тодорхойлох) салбарын буюу тусгайлсан хуулиар тусгайлсан бүрэн эрхийг тодорхойлох зарчмыг баримтална. Энэ нь хууль батлагдсанаар орон нутгийн удирдлага хуулийг хэрэглэх асуудалд дэвшил бий болно. Мөн түүнчлэн аймаг, сум,

баг, нийслэл, дүүрэг, хорооны төвшинд бүрэн эрхийг давхардуулж олгохгүй, нэг асуудлаар өөр түвшний байгууллага бүрэн эдлэх боломжийг багасгах, цаашид байхгүй болгох үндэс суурийг энэ хуулиар тавина. Харин газрын харилцаа, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, газрын хэвлийн баялаг, байгалийн нөөц ашиглах, бэлчээр ашиглах талаарх нутгийн удирдлагын байгууллагын онцгой бүрэн эрхийг энэ хуулиар тодорхойлно. Энэ нь нутгийн удирдлагын байгууллагын хэрэгжүүлэх бусад бүрэн эрхийг холбогдох хуулиар зохицуулахыг хязгаарлахгүй.

8. Засаг даргад нэр дэвшүүлэх, түүнийг огцруулах үндэслэл, журмыг Үндсэн хуульд нийцүүлэн “томилох” гэсэн агуулгаар гүнзгийрүүлэн зохицуулалт хийнэ. Төрийн бодлогын, хууль тогтоомжийн биелэлтийн талаар Засаг дарга дээд шатны Засаг дарга (Ерөнхий сайд)-ын өмнө хариуцлага хүлээх зарчмын дагуу огцруулах асуудлыг дээд шатны Засаг дарга, (Ерөнхий сайд) шууд шийдвэрлэж байхаар, харин Хурлын шийдвэрийг биелүүлэхгүй байгаа асуудлаар тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөж шийдвэрлэж байхаар тусгана.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

3 ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.ТОГТОХСҮРЭН

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулиар зохицуулагдах, суурь зарчим нь тодорхойлогдох харилцаа бол засаг захиргааны зохион байгуулалт, тухайн нэгж дэх удирдлагын асуудал юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлгээр уг харилцааг зохицуулах суурь үндсийг тодорхойлдог.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн төрийн байгууламжийн талаарх суурь үзэл санаа, Дөрөвдүгээр бүлэг, мөн түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн батлах үндэслэл болно.

Мөн Улсын Их Хурлаас баталсан 2020 оны 02 дугаар тогтоолд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиудтай цогц байдлаар хамтад нь батлахаар нэр зааж орсныг дурдах нь зүйтэй.

1992 оноос хойш тухайн харилцааг зохицуулсан 2 удаагийн хууль (1992 оны болон 2006 оны өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль) батлагдаж үйлчилж ирсэн байна. Дээрх хуулиудаар төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үе, мөн зах зээлийн эдийн засгийн харилцаанд ажиллаж чадахуйц нутгийн удирдлагын үйл ажиллагааны зарчим, арга, хэлбэрийг тодорхойлж байсан боловч Үндсэн хуулийн суурь үзэл санаа, зүйл, заалтыг гүнзгийрүүлж баяжуулах, нийгмийн харилцаанд шинээр бий болж буй арга, хэлбэрийг хүлээн зөвшөөрөх, зохицуулах зэрэг асуудлаар “хоцрогдож” ирсэн талаар төрөл бүрийн судалгаа, практик ажилтнуудын санал зөвлөмж гарсаар байна.

Дээр дурдсан зүйлүүд нь нэгжийн хуулийг шинэчлэн батлах хууль зүйн үндэслэл, практик шаардлагыг бий болгосон гэж хууль санаачлагч үзлээ.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна. Уг хуулийн төсөл нь Нийтлэг үндэслэл, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүү, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг хот, тосгонд шилжүүлэх, Нэгжийн

удирдлага бусад байгууллагатай харилцах, болон бусад гэсэн 6 бүлэг, Орон нутгийн чиг үүрэг, Нутгийн өөрийн удирдлага, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх төрийн удирдлага гэсэн 3 дэд бүлэг, 81 зүйлээс бүрдэнэ.

Үзэл баримтлалын нэг дэх хэсэгт дурдсанчлан уг хууль нь органик хууль (үндсэн хуулийг гүнзгийрүүлэн зохицуулсан хууль)-д хамаарах тул Үндсэн хуулийн үзэл санаа, зүйл, заалтыг гүнзгийрүүлэх, түүнд орсон нэр томьёог хэрэглэх, тодруулбал Үндсэн хуульд нийцүүлэх арга хэмжээг авна.

1. Хуулиар зохицуулагдах эхний бүлэг харилцаа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эрх зүйн байдал, засаг захиргааны хуваарь, тэдгээртэй холбогдох зохицуулалтууд:

1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш аймаг, сум, баг, мөн нийслэл, дүүрэг, хорооны чиг үүргийг хуулиар тусгайлан тодорхойлох, нэгж тус бүрийн чиг үүргийг зааглаж ялгаагүйгээс улбаалж дээр дурдсан нэгжүүдийн чиг үүрэг өөр хоорондоо холилдох, давхцах эсхүл хийдэл үүсэх, нэгжийн удирдлагын “ажил үүрэг”-ийг хуваарилахад ойлгомжгүй байдал үүсэх зэрэг сөрөг үр дагаварыг дагуулж ирэв. Энэ байдлыг залруулах зорилгоор нэгжүүдийн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлно:

- Иргэдэд хамгийн ойр нэгж болох баг, хорооны эрх зүйн байдлыг тодорхой болгох, энэ хүрээнд баг, хороо эрх зүйн харилцаанд оролцох эрх зүйн үндсийг бий болгох, баг хороонд нутгийн өөрийн удирдлагын бусад хэлбэрийг хэрэгжүүлэх, Үндсэн хуульд заасан зарчмын хүрээнд өдөр тутмынхаа тулгамдсан асуудлыг өөрсдөө бие дааж шийдвэрлэх, шийдвэрийн үр нөлөө, хүчин чадлыг дээшлүүлэх;
- Сум дүүрэг нь орон нутгийн өөрийн удирдлагын бие даасан цөм (суурь) нэгж байж, иргэдийн амьдралын тулгамдсан асуудлууд, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн зорилтыг шийдвэрлэх чиг үүрэг, бүрэн эрхтэй байх, үүнтэй холбоотойгоор энэ хуулиар бий болох орон нутгийн чиг үүргийг голлон хэрэгжүүлэх нэгж нь байх зэргээр нутгийн өөрийн удирдлагыг иргэдэд илүү ойр нэгжид төвлөрүүлэх;
- Аймаг нь сумдын нийтлэг эрх ашгийн төлөөлөл болохын зэрэгцээ төв засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, сум хоорондын асуудлыг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих чиглэл давамгайлсан чиг үүрэгтэй нэгж байхаар тодорхойлох. Энэ нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл Монгол Улсын хувьд чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх зарчим, журмыг шинээр зохицуулна. Үүнтэй уялдаатайгаар нэгж байгуулахад харгалзах үзүүлэлтүүдийг шинээр тодорхойлж, нэгжийг өөрчлөх асуудлыг нэг бүрчлэн шийдвэрлэх зохицуулалтыг бий болгоно. Нэгжийг өөрчлөх асуудлыг голлон боловсруулж, зохион байгуулах байгууллага нь Засгийн газар байна. Харин иргэдээс саналыг нь авах ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулах үүрэг хүлээх бөгөөд санал авах, үр дүнг тооцох журмыг Улсын Их Хурал тогтооно. Нэгжийг өөрчлөх асуудлаар иргэд санал тавих, Засгийн газар санаачлах үндэслэлийг хуулиар тодорхойлно.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоныг өөрийн удирдлагын хүрээнд эдийн засаг, нийгэм, аж ахуйн асуудлыг түлхүү шийдвэрлэх орон нутгийн корпораци хэлбэрт шилжих эрх зүйн үндэс бий болгохтой холбогдуулан хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, (аймаг, сум, баг, дүүрэг, хороо) түүний удирдлагын “Засаг захиргааны

шинжтэй” зарим чиг үүргийг хэрхэн яаж шилжүүлэх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага өөрийн нутаг дэвсгэр дэх хот, тосгоны өөрийн удирдлагатай харилцах суурь зарчмыг энэ хуулиар тогтооно.

3. Үндсэн хуулийн үзэл санааны дагуу нутгийн удирдлагыг хөгжүүлэх, бэхжүүлэх асуудал бол энэ хуулийн амин чухал асуудлын нэг байна.

- Эл хүрээнд юуны өмнө авах арга хэмжээ нь орон нутгийн чиг үүргийг тодорхойлох (ийм төрлийн чиг үүргийг орон нутгийн Хурал бие даан шийдвэрлэх бөгөөд төрөөс үүнд оролцохгүй), мөн түүнчлэн төрөөс орон нутгийн удирдлагад шилжүүлж болох болон шилжүүлж үл болох чиг үүргийн жагсаалтыг хуулиар тодорхойлно. Ингэхдээ чиг үүргийг аль болох иргэдэд ойр нэгжид хуваарилан, санхүүжилтийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх зарчмыг баримтална. Нутгийн өөрөө удирдах байгууллага орон нутгийн чиг үүргийг болон төрөөс шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ба эдгээрийн биелэлтэд төв Засгийн газар засаг төрийн төлөөлөгчөөрөө дамжуулан хяналт тавина.
- Орон нутгийн бие даасан байдлыг хангах хүрээнд өөрийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор иргэдийн шууд удирдлагын хэлбэр болох иргэдийн нийтийн Хурлын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг тусгайлан зохицуулахын сацуугаар бусад хэлбэр (иргэдийн санаачлах эрх, орон нутгийн санал асуулга зэрэг)-ийг хуульчилна.
- Иргэдийн Хурлын төлөөлөгчийн эрх зүйн байдлыг дэлгэрүүлж, төлөөлөгч ба сонгогч иргэний хооронд “амьд харилцаа” байх нөхцлийг бүрдүүлэх заалтуудыг хуулийн төсөлд оруулна. Үүнд: Төлөөлөгч иргэддээ тайлагнах, тэдний захиа даалгаврыг биелүүлэх, төлөөлж буй иргэдийн нэрийн өмнөөс гүйцэтгэх байгууллагатай харилцах (Засаг даргыг хянах, санал асуулга тавих гэх мэт) зэрэг өргөн эрх мэдэл, үүргийг төлөөлөгчид ногдуулна. Мөн нөгөө талаас үүргээ биелүүлэхгүй байгаа төлөөлөгчид хүлээлгэх хариуцлагыг шат дараатайгаар авахаар нарийвчлан зохицуулна.

Иргэдийн Хурал хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чиг үүргээ биелүүлэхгүй байх, иргэд олон түмний итгэлийг хөсөрдүүлэх, бүлэглэх, улс төржих явдал цөөнгүй гарсан бөгөөд ийм байдлыг цаашид гаргуулахгүй байх зорилгоор төв засгийн хяналтыг тодруулж Хурлыг аймаг, нийслэлийн Засаг даргын санал оруулснаар Засгийн газар тараах тараах шийдвэр гаргах зэрэг арга хэмжээ авах эрхтэй байхаар хуульчилна. Энэ хуулийн төслийн хүрээнд төв Засгийн газрын бодлого болон орон нутгийн ашиг сонирхол өөр байгаа тохиолдолд төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улсын хувьд Үндсэн хууль, бусад хуулийн хүрээнд асуудлыг хэрхэн шийдвэрлэж байх хуулийн механизмуудыг шинээр тодорхойлно.

- Нэгдмэл улсын хувьд төв Засгийн газраас нутгийн өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих нь зүй ёсны хэрэг боловч ингэснээр нутгийн өөрийн удирдлагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болохгүй. Иймээс нутгийн өөрийн удирдлагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах Үндсэн хуулийн механизмыг бүрдүүлэх талаар зохицуулалт энэ хуульд шинээр тусгана. Гадаад орнуудын жишиг мөн адил ийм байна.
- Сүүлийн жилүүдийн судалгаанд иргэдийн зүгээс байнга гаргадаг, зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудал нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг улс төрөөс ангид байлгах асуудал юм. Энэ зорилгоор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаагаа намын бүлгээр бус, байнгын болон түр хороо, ажлын хэсэг зэрэг өөрийн дотоод зохион байгуулалтын бүтэц,

арга хэлбэрээр явуулах зохицуулалтыг оруулна. Сумын Хуралын сонгуульд улс төрийн нам нэр дэвшүүлэхгүй байх, мөн бусад хурлын хувьд нэр дэвшүүлсэн нам нь төлөөлөгчөөр сонгогдсон гишүүндээ үүрэг хүлээлгэхгүй байхаар зохицуулна.

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын байгууллагыг адилтгах бус түүний чиг үүрэг, суурийн газрын онцлогт нийцүүлэн түүнийг сонгож байгуулах арга журмыг Үндсэн хуулийн суурь зарчимд нийцүүлэн тогтооно. Ингэхдээ аймаг, сум, дүүргийн хувьд тухайн орон нутагт байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох, харин нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас сонгож байгуулахаар зохицуулна.
4. Орон нутгийг бие даалгах, эдийн засаг, нийгмийн асуудлаа шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн цогцолбор болоход түүний эдийн засаг, санхүүгийн үндэс голлох үүрэгтэй билээ. Энэ чиглэлээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд энэ хууль, мөн төсвийн тухай төрийн болон орон нутгийн өмчийн тухай зэрэг хуулиудаар гүнзгийрүүлэн зохицуулна.
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжийн орлогын албан татварын тодорхой хувийг тухайн нэгжид хуулиар хуваарилах зарчмыг энэ хуульд тусгана. Татварын ерөнхий хуулийн 7.2.15-д заасан татварын орлогыг орон нутагт бүрэн үлдээх.
 - Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж орон нутгийн төсвийн төслийг боловсруулах, төсвөө бие даан батлах, төрөөс олгох татаас, тусгай зориулалтын шилжүүлгийг тухайн нэгж тус бүрт нэр заан батлах зарчмыг баталгаажуулах.
 - Орон нутгийн төсвийн төлөвлөлт нь улсын болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцсэн байх шаардлагыг тусгах.
 - Орон нутгийн санг бүрдүүлэхэд орон нутгийн санаачилга, оролцоог нэмэгдүүлж урамшуулах зохицуулалтыг бий болгох.
 - Орон нутгийн өмч үүсэх эрх зүйн үндсийг тодорхой болгох, орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчим, орон нутаг дахь төрийн өмчийн удирдлагыг хуулиар тодорхойлсон хязгаарын хүрээнд хэрэгжүүлэх журам. Орон нутгийн өмчид тавих хяналтыг тодорхой болгох.

Энэ талаар Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд ерөнхий суурь зарчмыг заах ба дээр дурдсан хуулиудаар нарийвчилсан зохицуулалтыг хийнэ.

5. Үндсэн хуулийн 59.2-т заасан нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын онцлогт нийцүүлэн хуулиар тогтоох үндэслэл, журмыг энэ хуулиар дэлгэрүүлэн зохицуулна.
6. Улсын Их Хурал бусад хуулийг батлахдаа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн суурь зарчимд нийцүүлэх чиглэл баримтална.
7. Орон нутгийн Хурал, Засаг даргын бүрэн эрхийг тодорхойлохдоо энэ хуулиар аль болох ерөнхийлөн заах (суурь зарчмыг тодорхойлох) салбарын буюу тусгайлсан хуулиар тусгайлсан бүрэн эрхийг тодорхойлох зарчмыг баримтална. Энэ нь хууль батлагдснаар орон нутгийн удирдлага хуулийг хэрэглэх асуудалд дэвшил бий болно. Мөн түүнчлэн аймаг, сум,

баг, нийслэл, дүүрэг, хорооны төвшинд бүрэн эрхийг давхардуулж олгохгүй, нэг асуудлаар өөр түвшний байгууллага бүрэн эдлэх боломжийг багасгах, цаашид байхгүй болгох үндэс суурийг энэ хуулиар тавина. Харин газрын харилцаа, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, газрын хэвлийн баялаг, байгалийн нөөц ашиглах, бэлчээр ашиглах талаарх нутгийн удирдлагын байгууллагын онцгой бүрэн эрхийг энэ хуулиар тодорхойлно. Энэ нь нутгийн удирдлагын байгууллагын хэрэгжүүлэх бусад бүрэн эрхийг холбогдох хуулиар зохицуулахыг хязгаарлахгүй.

8. Засаг даргад нэр дэвшүүлэх, түүнийг огцруулах үндэслэл, журмыг Үндсэн хуульд нийцүүлэн “томилох” гэсэн агуулгаар гүнзгийрүүлэн зохицуулалт хийнэ. Төрийн бодлогын, хууль тогтоомжийн биелэлтийн талаар Засаг дарга дээд шатны Засаг дарга (Ерөнхий сайд)-ын өмнө хариуцлага хүлээх зарчмын дагуу огцруулах асуудлыг дээд шатны Засаг дарга, (Ерөнхий сайд) шууд шийдвэрлэж байхаар, харин Хурлын шийдвэрийг биелүүлэхгүй байгаа асуудлаар тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөж шийдвэрлэж байхаар тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх зүйн орчин боловсронгуй болж, хууль хэрэглээний болоод зохион байгуулалт, удирдлагын хувьд нэг мөр, ойлгомжтой болохоос гадна Үндсэн хуульд оруулсан нутгийн удирдлагын нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалтай бүрэн нийцэх бөгөөд хууль хоорондын уялдаа хангагдаж, хэрэгжилтийг нэг мөр хангах нөхцөл бүрдэнэ.

Хууль батлагдсаны дараа хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын асуудлаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тусгайлан үнэлгээг хийлгэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг сайжруулах зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Тус хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тухай хууль болон Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаас гадна 2006 онд батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай мөн 2017 онд батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг боловсруулах болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

4 ХУУЛИЙН ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах, иргэд орон нутгийн үйл хэрэгт шууд болон сонгож байгуулсан төлөөллийн байгууллагаараа дамжуулж оролцох эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршино.

2 дугаар зүйл.Хуулийн зохицуулах харилцаа

2.1.Энэ хуулиар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний чиг үүрэг, эдийн засгийн үндэс, өөрчлөх үндэслэл, журам, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх өөрийн болон төрийн удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, нутгийн өөрийн удирдлагын байгууллагын эрх хэмжээ, зохион байгуулалт, бүх шатны Засаг даргын бүрэн эрх, нутгийн удирдлагаас бусад байгууллагатай харилцах харилцааг зохицуулна.

2.2.Монгол Улсын нийслэл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болохтой холбоо бүхий харилцааг энэ хуулиар зохицуулна.

2.3.Хот, тосгоны өөрийн удирдлагад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг шилжүүлж, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулна.

3 дугаар зүйл.Хууль тогтоомж

3.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын чиг үүрэг, бүрэн эрхийг бусад хуулиар тодорхойлохдоо энэ хуульд заасан зарчим, нийтлэг зохицуулалтыг баримтална.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“нэгж” гэж аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороог;

4.1.2.“нэгжийн удирдлага” гэж нэгж дэх нутгийн өөрийн удирдлага болон тухайн Хурлын

шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт харьяа нутаг дэвсгэртээ засаг төрийн төлөөлөгчийн хувьд төрийн удирдлагыг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, тогтолцоог;

4.1.3.“нутгийн өөрийн удирдлага” гэж иргэд шууд буюу нутгийн өөрөө удирдах төлөөллийн байгууллагаараа дамжуулж орон нутгийг удирдах үйл ажиллагааг;

4.1.4.“нэгжийн гүйцэтгэх удирдлага” гэж нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.5.“орон нутгийн чиг үүрэг” гэж хуульд заасны дагуу нутгийн өөрийн удирдлагад тусгайлан олгосон, нэгжийн гүйцэтгэх удирдлага шууд хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлыг;

4.1.6.“нутгийн өөрөө удирдах байгууллага” гэж аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдээс сонгогдсон Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн шууд оролцоо бүхий Нийтийн Хурлыг;

4.1.7.“орон нутгийн эрх хэмжээ” гэж нэгжийн удирдлагад хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, нутгийн өөрийн удирдлага болон нэгжийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг;

4.1.8.“бүрэн эрх” гэж нэгжийн удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлэхэд тэдэнд хуулиар олгосон эрх, үүргийг;

4.1.9.“шилжүүлсэн чиг үүрэг” гэж хууль тогтоомжийн дагуу төрөөс нутгийн нэгжийн удирдлагад шилжүүлсэн тодорхой бүрэн эрхийг;

4.1.10.“орон нутгийн өмч” гэж хууль тогтоомжоор нутгийн өөрөө удирдах байгууллагад олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд орон нутгийн санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор нутгийн өөрөө удирдах байгууллага эзэмших, ашиглах, захиран зарцуулах эд хөрөнгийг;

4.1.11.“төв засгийн хяналт” гэж хууль тогтоомжоор нутгийн өөрийн удирдлагын эрх хэмжээг тогтоох, нутгийн өөрөө удирдах байгууллагын хэм хэмжээ тогтоосон актыг бүртгэх, Хурлын шийдвэрт засаг төрийн төлөөлөгчийн хувьд хориг тавих, нутгийн өөрөө удирдах байгууллагыг хуульд заасан журмын дагуу тараах, нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх болон хуульд заасан бусад хяналтыг;

4.1.12.“нутгийн өөрийн удирдлагын хяналт” гэж нутгийн өөрөө удирдах байгууллагаас нэгжийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавьж буй хяналтыг.

5 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж эрх зүйн харилцаанд оролцох

5.1.Аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо нь нийтийн эрх зүйн этгээд байна.

5.2.Аймаг, сум, нийслэл, дүүрэг иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно.

5.3.Эрх зүйн харилцаанд аймаг, сум, нийслэл, дүүргийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний эрх олгосноор Засаг дарга төлөөлнө.

6 дугаар зүйл.Аймаг

6.1.Аймаг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, сум хоорондын үйл ажиллагааг зохицуулах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналтыг хэрэгжүүлэх нэгж мөн.

7 дугаар зүйл.Сум

7.1.Сум нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих үндсэн нэгж мөн.

8 дугаар зүйл.Баг

8.1.Баг нь нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах, иргэдэд засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээ хүргэх анхан шатны нэгж мөн.

8.2.Баг нь аравтын зохион байгуулалттай байна. Аравтын хуваарийг газар нутгийн байршил, хүн амын суурьшил, өрхийн тоог харгалзан багийн иргэдийн Нийтийн Хурал тогтооно.

9 дүгээр зүйл.Нийслэл

9.1.Нийслэл нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналтыг хэрэгжүүлэх нэгж мөн.

9.2.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

10 дугаар зүйл.Дүүрэг

10.1.Дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, иргэдэд засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах үндсэн нэгж мөн.

11 дүгээр зүйл.Хороо

11.1.Хороо нь иргэдэд засаг захиргааны үйлчилгээ хүргэх, нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах чиг үүрэг бүхий анхан шатны нэгж мөн.

11.2.Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна. Хэсгийн хуваарийг хүн амын суурьшил, өрхийн тоог харгалзан хорооны иргэдийн Нийтийн Хурал тогтооно.

12 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарчим

12.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг мөрдөхийн зэрэгцээ доор дурдсан зарчмыг баримтална:

12.1.1.төрийн байгууламжийн нэгдмэл байдлыг хангах;

12.1.2.улсын болон орон нутгийн ашиг сонирхлыг хослуулах;

12.1.3.нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулах зарчмыг хэрэгжүүлэхдээ төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг зааглах;

12.1.4.нутгийн өөрийн удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх, үүний төлөө хариуцлага хүлээх;

12.1.5.нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцохгүй байх;

12.1.6.нутгийн өөрийн удирдлага нь тухайн нэгжид оршин суугаа иргэдийн хүсэл зоригийн илэрхийлэл байх, иргэдийн саналыг харгалздаг байх;

12.1.7.ил тод байх, иргэдийг мэдээллээр хангах;

12.1.8.асуудлыг шийдвэрлэхдээ хамтын зарчмыг баримтлах.

13 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх

13.1.Аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг тухайн орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

13.2.Аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг Засгийн газар санаачилна.

13.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэхдээ тухайн нэгжийн иргэдийн саналыг авсан байна. Санал авах ажлыг харьяалах иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хариуцан зохион байгуулах бөгөөд санал авах журмыг Улсын Их Хурал тогтооно. Холбогдох нэгжийн сонгуулийн эрх бүхий иргэдийн олонх оролцсон бол уг санал авах ажлыг хүчинтэйд тооцно.

13.4.Багийг өөрчлөх асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоо, уламжлал, эрхлэх аж ахуй, зам харилцааны онцлогийг харгалзан, аймгийн Засаг дарга өргөн мэдүүлснээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

13.5.Хороог өөрчлөх асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоо, нийгмийн үйлчилгээг иргэдэд хүргэх нөхцөлийг харгалзан, нийслэлийн Засаг дарга өргөн мэдүүлснээр нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

13.6.Баг, хороог өөрчлөхдөө тухайн баг, хорооны иргэдийн санал авах бөгөөд санал авах ажлыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.

13.7.Ээлжит сонгууль явуулахаас өмнөх нэг жилийн дотор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэхгүй.

14 дүгээр зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэс, баг, хорооны нутаг дэвсгэрийн зааг

14.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

14.2.Баг, хорооны нутаг дэвсгэрийн заагийг аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ

15 дугаар зүйл.Нэгжийн эдийн засгийн үндсийг бүрдүүлэх талаар төр, орон нутгийн үүрэг

15.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндсийг бүрдүүлэх нь төрийн үүрэг мөн. Төр энэхүү үүргээ хэрэгжүүлэхдээ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дараах эрхийн баталгааг хангана:

15.1.1.нутаг дэвсгэрийнхээ хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх;

15.1.2.хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох;

15.1.3.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг улсын төсвөөс хуваарилуулах;

15.1.4.байгалийн баялгийн үр өгөөж, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад боломжид түшиглэн хөгжих.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан төрийн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгана.

15.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүүгийн үндсийг бүрдүүлэхэд тухайн нэгж өөрийн нөөц бололцоог дайчлан ажиллах үүрэгтэй.

16 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн эрх мэдэл

16.1.Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь бие даасан төсөвтэй байна.

16.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн эх үүсвэр нь татварын болон татварын бус орлого, улсын төсвийн санхүүжилт болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

16.3.Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгийг гагцхүү энэ хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулна.

16.4.Сум, дүүргийн төсвийг боловсруулж, батлахдаа харьяалах баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас гаргасан саналыг авч тусгасан байна. Баг, хорооны үйл ажиллагааны зардлыг харьяалах сум, дүүргийн төсөвт тусгайлан батална.

16.5.Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

17 дугаар зүйл.Орон нутгийн сан

17.1.Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь энэ хуульд заасан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх зориулалт бүхий Төсвийн тухай хуульд зааснаас бусад сантай байж болно. Энэ санг бүрдүүлэх эх үүсвэр нь төсвийн бус хөрөнгө байна.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих журмыг тухайн шатны Хурал тогтооно.

17.3.Энэ хуулийн 17.2-т заасны дагуу тогтоосон журмыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу бүртгүүлнэ.

18 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмч

18.1.Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь өмчтэй байна.

18.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмч нь нийтийн зориулалттай өмч болон өөрийн өмчөөс бүрдэнэ. Өөрийн өмч нь албан хэрэгцээний болон аж ахуйн зориулалттай байна.

18.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга тус тус хэрэгжүүлнэ.

18.4.Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хуулийн этгээд байгуулах эрхтэй.

18.5.Орон нутгийн өмчит болон өмч давамгайлсан компани нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр үнэт цаас гаргаж болно.

18.6.Орон нутгийн өмчийн харилцааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН УДИРДЛАГА

Нэгдүгээр дэд бүлэг Орон нутгийн чиг үүрэг

19 дүгээр зүйл.Орон нутгийн чиг үүргийг тогтоох зарчим

19.1.Орон нутгийн чиг үүргийг тогтооход дараах зарчмыг баримтална:

19.1.1.чиг үүргийг иргэдэд хамгийн ойр нэгжид болон зохих түвшинд оновчтой хуваарилах;

19.1.2.чиг үүрэг хэрэгжүүлэх санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэдэг байх;

19.1.3.чиг үүргийг давхардуулахгүй байх;

19.1.4.нэгжийн удирдлагад бүрэн эрх олгохдоо энэ хуулиар тогтоосон нэгж тус бүрийн чиг үүрэгт нийцүүлж ялгаатай хуваарилах;

19.1.5.тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэх.

20 дугаар зүйл.Орон нутгийн чиг үүрэг

20.1.Эдийн засаг, төсвийн талаар орон нутаг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.1.1.орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал;

20.1.2.орон нутгийн өмчийн удирдлага;

20.1.3.орон нутгийн төсөв, татвар, төлбөр, хураамж;

20.1.4.орон нутгийн сан.

20.2.Бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх талаар орон нутаг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.2.1.орон нутгийн боловсон хүчний асуудал;

20.2.2.орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудал;

20.2.3.орон нутгийн нийгэм, соёлын асуудал;

20.2.4.орон нутгийн байгаль орчны асуудал;

20.2.5.орон нутгийн дэд бүтцийн хөгжлийн асуудал;

20.2.6.үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуйн асуудал.

20.3.Зохицуулалтын шинжтэй дараах чиг үүргийг орон нутаг хэрэгжүүлнэ:

20.3.1.хүн амын унд, ахуйн хэрэгцээний ус хангамж;

- 20.3.2.худалдаа, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ;
- 20.3.3.орон нутгийн чанартай нийтийн тээвэр, такси үйлчилгээ;
- 20.3.4.хот суурингийн замын хөдөлгөөн, авто зогсоол;
- 20.3.5.гудамж, талбай, барилга, байшингийн хаягжилт;
- 20.3.6.хөшөө дурсгалын байршил, хамгаалалт;
- 20.3.7.хот тохижилт, явган хүн, тоглоомын талбайн байгууламж;
- 20.3.8.олон нийтийн амралт, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж;
- 20.3.9.орон нутгийн чанартай аялал жуулчлалын менежмент;
- 20.3.10.орон нутгийн чанартай бэлчээрийн менежмент;
- 20.3.11.хог хаягдлын менежмент;
- 20.3.12.оршуулгын газрын зохицуулалт.

20.4.Үйлчилгээ, аж ахуйн талаар орон нутаг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 20.4.1.боловсролын байгууллагын барилга байгууламж;
- 20.4.2.эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж;
- 20.4.3.орон нутгийн харьяалалтай биеийн тамир, спортын барилга байгууламж;
- 20.4.4.орон нутгийн чанартай номын сан, музей, театр, соёлын төвийн барилга

байгууламж;

- 20.4.5.инженерийн шугам сүлжээ, суваг шуудуу;
- 20.4.6.орон нутгийн цэвэрлэх байгууламж;
- 20.4.7.орон нутгийн зам, гүүр;
- 20.4.8.орон нутгийн суурин газрын гэрэлтүүлэг

20.5.Бусад чиг үүрэг:

- 20.5.1.нутгийн өөрийн удирдлагын хяналт.

20.6.Энэ хуулийн 20.1, 20.2, 20.3, 20.4, 20.5-д зохих нэмэлт оруулсны үндсэн дээр орон нутгийн чиг үүргийг нэмэгдүүлж болно.

20.7.Нутгийн өөрөө удирдах байгууллага энэ зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4, 20.5-д заасан чиг үүргээс гадна Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан нутаг дэвсгэрийнхээ тодорхой асуудлыг бие даан шийдвэрлэх эрхтэй.

21 дүгээр зүйл.Аймгийн чиг үүрэг

21.1.Аймаг нь доор дурдсан асуудлаар энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 21.1.1.аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал;
- 21.1.2.аймгийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хяналт;
- 21.1.3.аймгийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;
- 21.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд татвар, хураамж, төлбөрийн хувь хэмжээ

тогтоох асуудал;

21.1.5.аймгийн орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хуваарилалт, тайлан, хяналт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;

21.1.6.аймгийн боловсон хүчний бодлого төлөвлөлт, боловсон хүчнийг бэлтгэх, ажиллах, нөхцлийг хангах асуудал;

- 21.1.7.аймгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах бодлого;
- 21.1.8.аймгийн хүн амын бодлого;
- 21.1.9.аймгийн соёл, урлагийн бодлого;
- 21.1.10.байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх хөтөлбөр, төлөвлөгөө, хяналт;
- 21.1.11.хот суурин газрын хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, хяналт;
- 21.1.12.хот байгуулалт, барилга архитектурын стандарт;
- 21.1.13.аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн бодлого;
- 21.1.14.орон нутгийн чанартай нийтийн тээвэр, такси үйлчилгээний зохицуулалт;
- 21.1.15.хот суурингийн замын хөдөлгөөний зохицуулалт;
- 21.1.16.гудамж, талбай, барилга, байшингийн хаягжилтийн зохицуулалт;
- 21.1.17.хөшөө дурсгал байгуулах зөвшөөрөл;
- 21.1.18.аймгийн аялал жуулчлалын бодлого, менежмент;
- 21.1.19.аймгийн бэлчээр, хадлангийн талбайн зохистой ашиглалт хамгаалалт;
- 21.1.20.сум дундын отрын нөөц нутаг, түүний заагийг тогтоох асуудал;
- 21.1.21.аюултай болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежмент;
- 21.1.22.оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт.

22 дугаар зүйл.Сумын чиг үүрэг

- 22.1.Сум нь доор дурдсан асуудлаар энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 22.1.1.сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал;
 - 22.1.2.сумын өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хяналт
 - 22.1.3.сумын төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт
 - 22.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд татвар, хураамж, төлбөрийн хувь хэмжээ тогтоох асуудал;
 - 22.1.5.орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хуваарилалт, тайлан, хяналт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;
 - 22.1.6.байгаль орчин хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх хөтөлбөрийн хэрэгжилт;
 - 22.1.7.сумын нутаг дэвсгэр дэх ой, ургамал, ан амьтан, ус, рашаан, байгалийн нөөцийн ашиглалт;
 - 22.1.8.суурин газрын ерөнхий төлөвлөгөө, түүний хэрэгжилт;
 - 22.1.9.хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилт;
 - 22.1.10.сумын хүн амын унд, ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, түүний чанар, аюулгүй байдлыг хангах;
 - 22.1.11.худалдаа, нийтийн аж ахуйн үйлчилгээний зохицуулалт, зөвшөөрөл, хяналт;
 - 22.1.12.орон сууцны хуваарилалт, арчилгаа;
 - 22.1.13.суурин газрын авто зогсоолын байршил, арчилгаа;
 - 22.1.14.хөшөө дурсгалын байршил, хамгаалалт;

22.1.15.нийтийн эзэмшлийн зам талбай, байгууламжийн арчилгаа, хамгаалалт;

22.1.16.олон нийтийн амралт, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн байршил, арчилгаа, хамгаалалт;

22.1.17.бэлчээр ашиглах хуваарилалт;

22.1.18.хадлангийн талбайг зохистой ашиглах асуудал;

22.1.19.энгийн хог хаягдлын цэгийн байршил, менежмент;

22.1.20.оршуулгын газрын зохицуулалт.

23 дугаар зүйл.Багийн чиг үүрэг

23.1.Баг нь доор дурдсан асуудлаар энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.1.1.нутаг дэвсгэрийнхээ иргэдэд засаг захиргааны үйлчилгээ хүргэх ажлыг зохион байгуулах;

23.1.2.хууль тогтоомжид заасан болон өөрийн санаачилсан асуудлаар нутаг дэвсгэрийнхээ иргэдийн нийтлэг санал, хүсэлтийг авах ажлыг зохион байгуулж, зохих шатны байгууллага, албан тушаалтанд уламжлах;

23.1.3.хууль, зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутаг дэвсгэрийнхээ амьдралын тодорхой асуудлыг бие даан шийдвэрлэх;

23.1.4.улс, аймаг, сумын чанартай асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд багийн хүн амыг зохион байгуулж оролцуулах;

23.1.5.бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлан, тариалан, бэлчээр, уст цэгийг хамгаалах, ашиглах, зохицуулах;

23.1.6.тухайн нутаг дэвсгэрийнхээ байгаль орчны тэнцвэрт байдалд тавих хяналтад иргэдийн оролцоог хангах;

23.1.7.багийн иргэдээр шийдвэрлүүлэхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шилжүүлсэн асуудал.

24 дүгээр зүйл.Нийслэлийн чиг үүрэг

24.1.Нийслэл нь доор дурдсан асуудлаар энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.1.1.нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал;

24.1.2.нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хяналт;

24.1.3.нийслэлийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;

24.1.4.хууль тогтоомжид заасан хүрээнд татвар, хураамж, төлбөрийн хувь хэмжээ тогтоох асуудал;

24.1.5.нийслэлийн орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хуваарилалт, тайлан, хяналт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;

24.1.6.нийслэлийн хүн амын бодлого;

24.1.7.нийслэлийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах бодлого;

24.1.8.нийслэлийн соёл, урлагийн бодлого;

24.1.9.байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх хөтөлбөр, төлөвлөгөө, хяналт.

25 дугаар зүйл. Дүүргийн чиг үүрэг

25.1. Дүүрэг нь доор дурдсан асуудлаар энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25.1.1. дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал;

25.1.2. дүүргийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хяналт;

25.1.3. дүүргийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;

25.1.4. хууль тогтоомжид заасан хүрээнд татвар, хураамж, төлбөрийн хувь хэмжээ тогтоох асуудал;

25.1.5. дүүргийн орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хуваарилалт, тайлан, хяналт, бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;

25.1.6. дүүргийн хүн амын эрүүл мэндийн үйлчилгээ;

25.1.7. дүүргийн нийгэм, соёлын үйлчилгээ;

25.1.8. байгаль орчин хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх хөтөлбөрийн хэрэгжилт;

25.1.9. дүүргийн нутаг дэвсгэр дэх ой, ургамал, ан амьтан, ус, рашаан, байгалийн нөөцийн ашиглалт;

25.1.10. дүүргийн ерөнхий төлөвлөгөө, түүний хэрэгжилт;

25.1.11. дүүргийн нутаг дэвсгэр дэх цэвэрлэх байгууламж үерийн далан, суваг шуудуу;

25.1.12. дүүргийн хүн амын унд, ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, түүний чанар, аюулгүй байдлыг хангах;

25.1.13. худалдаа, нийтийн аж ахуйн үйлчилгээний зохицуулалт, зөвшөөрөл, хяналт;

25.1.14. дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн байгууламжийн цэвэрлэгээ, нийтийн ариун цэвэр;

25.1.15. хот суурингийн газрын авто зогсоолын байршил, арчилгаа;

25.1.16. нийтийн эзэмшлийн зам талбай, байгууламжийн арчилгаа, хамгаалалт;

25.1.17. олон нийтийн амралт, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн байршил, арчилгаа, хамгаалалт;

25.1.18. энгийн хог хаягдлын цэгийн байршил, менежмент;

25.1.19. дүүргийн нутаг дэвсгэр дэх сургуулийн өмнөх болон бага, дунд, боловсролын байгууллага, дүүргийн эмнэлгийн барилга объектын засвар, арчилгаа.

26 дугаар зүйл. Хорооны чиг үүрэг

26.1. Хороо нь доор дурдсан асуудлаар энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

26.1.1. нутаг дэвсгэрийнхээ иргэдэд засаг захиргааны үйлчилгээ хүргэх ажлыг зохион байгуулах;

26.1.2. хуульд заасан болон өөрийн санаачилсан асуудлаар нутаг дэвсгэрийнхээ иргэдийн нийтлэг санал, хүсэлтийг авах ажлыг зохион байгуулж, зохих шатны байгууллага, албан тушаалтанд уламжлах;

26.1.3. хууль, зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг бие даан шийдвэрлэх;

26.1.4.улс, нийслэл, дүүргийн чанартай асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хорооны хүн амыг зохион байгуулж оролцуулах;

26.1.5.хуульд заасны дагуу тухайн нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшлийн газар, зам талбайн газар зохион байгуулалт, орчны эрүүл ахуй, ариун цэврийн байдалд тавих хяналтад иргэдийн оролцоог хангах;

26.1.6.хорооны иргэдээр шийдвэрлүүлэхээр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шилжүүлсэн асуудал.

27 дугаар зүйл. Чиг үүрэг шилжүүлэх

27.1.Төрийн чиг үүргийг хууль, нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид шилжүүлж болно.

27.2.Энэ хуулийн 27.1-д нэгжид төрийн чиг үүргийг шилжүүлэхдээ тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хамтад нь шийдвэрлэнэ.

27.3.Өөр өөр шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид төрийн чиг үүргийг шилжүүлэхдээ түүний хүрээ, хязгаарыг нэгж тус бүрээр тодорхойлж, тайлагнах, хяналт тавих журмыг хууль, гэрээнд тодорхой заана.

27.4.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид шилжүүлж болох чиг үүрэгт дараах чиг үүрэг орно:

27.4.1.хөдөлмөр эрхлэлт;

27.4.2.хүн амын шилжилт хөдөлгөөний бүртгэл;

27.4.3.иргэний болон хуулийн этгээдийн бүртгэл;

27.4.4.цэргийн бүртгэл;

27.4.5.мал эмнэлгийн үйлчилгээ, малын үржил, селекц;

27.4.6.татвар, хураамж, төлбөр хураалт;

27.4.7.байгаль орчны хамгаалалт;

27.4.8.газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар олголт, хяналт;

27.4.9.нийгмийн халамж үйлчилгээ;

27.4.10.хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа;

27.4.11.цахилгаан дулаан хангамж;

27.4.12.шуудангийн үйлчилгээ;

27.4.13.бэлчээр хамгаалалт, усжуулалт;

27.4.14.эрүүл мэндийн анхан шатны тусламж, түргэн тусламжийн үйлчилгээ;

27.4.15.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагаа;

27.4.16.онцгой байдлын болон гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа;

27.4.17.түүхэн дурсгалт зүйлийн хамгаалалт.

28 дугаар зүйл. Чиг үүрэг үл шилжүүлэх

28.1.Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын хэрэгжүүлэх дараах чиг үүргийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид шилжүүлж үл болно:

28.1.1.гаалийн алба;

28.1.2.дипломат алба;

28.1.3.мэргэжлийн хяналт;

- 28.1.4.зэвсэгт хүчин, бусад цэрэг;
- 28.1.5.татварын алба;
- 28.1.6.тусгай алба;
- 28.1.7.гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба;
- 28.1.8.цагдаагийн алба;
- 28.1.9.Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан байгууллага.

Хоёрдугаар дэд бүлэг **Нутгийн өөрийн удирдлага**

29 дүгээр зүйл.Нутгийн өөрөө удирдах ёс

29.1.Нутгийн өөрөө удирдах ёс гэж орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн асуудлыг нутгийн өөрөө удирдах байгууллага төлөөллийн зарчмаар, иргэд шууд оролцооны зарчмаар бие даан шийдвэрлэхийг ойлгоно.

30 дугаар зүйл.Нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх иргэний эрх

30.1.Иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, арван дөрөвдүгээр зүйл, арван зургаадугаар зүйлийн 9 дэх хэсгийг үндэслэн шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулж нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй.

30.2.Иргэн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдох, төлөөлөгчийг сонгох; баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд өөрөө оролцох; нутгийн өөрийн удирдлагын байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, хууль тогтоомжид заасан журмын дагуу мэдээлэл авах эрхтэй.

31 дүгээр зүйл.Нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх хэлбэр

31.1.Иргэдийн төлөөллийн байгууллагын чиг үүргийг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлнэ.

31.2.Нутгийн өөрийн удирдлагад иргэн дараах хэлбэрээр шууд оролцоно:

31.2.1.баг, хорооны иргэдийн Нийтийн Хуралд саналын эрхтэй оролцох;

31.2.2.тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн тодорхой асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр санал гаргах.

31.2.3.энэ хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу иргэд сайн дураараа үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх, нэг удаагийн эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах.

32 дугаар зүйл.Нутгийн өөрийн удирдлага дахь иргэний оролцоо

32.1.Сум, баг, дүүрэг, хороо, аравт, хэсгийн тулгамдсан асуудлыг хэлэлцэх, зөвлөмж гаргах зорилгоор сонгуулийн эрх бүхий иргэд сайн дураараа хамтарч үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх эрхтэй.

32.2.Энэ зүйлийн 32.1-д заасны дагуу гаргасан санал, зөвлөмжийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэх үүрэгтэй.

32.3.Иргэн сум, дүүргийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар нэг удаагийн эсхүл хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахыг санаачлах эрхтэй. Энэхүү санаачлагыг сумын сонгуулийн эрх бүхий иргэдийн 10-аас доошгүй, дүүргийн сонгуулийн эрх бүхий иргэдийн 5-аас доошгүй хувь нь дэмжиж, гарын үсэг зурсан тохиолдолд сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэх үүрэгтэй.

32.4.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар шаардлагатай гэж үзвэл хуульд заасны дагуу зөвлөлдөх санал асуулга явуулж болно.

33 дугаар зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал

33.1.Иргэдийн Нийтийн Хурал нь шууд ардчиллын зарчмын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг, хуулиар олгогдсон бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг, иргэдийн өөрийн удирдлагын байгууллага байна.

33.2.Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

33.3.Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд тухайн баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэн бүр оролцох эрхтэй.

33.4.Иргэн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд биеэр хүрэлцэн ирснээр баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын оролцогч болно.

33.5.Иргэдийн Нийтийн Хурлын оролцогч дараах эрх, үүрэгтэй байна:

33.5.1.хэлэлцэх асуудал санаачлах;

33.5.2.асуудал шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;

33.5.3.Хурлын шийдвэрийг тайлбарлан таниулах;

33.5.4.Хурлын хуралдааны даргыг сонгох, түүнд сонгогдох;

33.5.5.хуралдааны дэгийг сахих.

33.6.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаан аравт, хэсэг тус бүрийн төлөөллийг хангах зарчмыг баримтлан багт 3 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

33.7.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь дараах нийтлэг бүрэн эрхтэй:

33.7.1.баг, хорооны чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;

33.7.2.Хурлын хуралдааны дэг, зохион байгуулалтын бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;

33.7.3.Хурлын хуралдааны даргыг сонгох;

33.7.4.баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх;

33.7.5.Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх;

33.7.6.Засаг даргыг хууль тогтоомжид заасан үндэслэлээр огцруулах санал гаргах;

33.7.7.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;

33.7.8.хуульд заасан бусад бүрэн эрх.

33.8.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөл нь баг, хорооны Засаг дарга болон өмнөх хуралдааны дарга, аравт, хэсгийн ахлагч нараас бүрдэх бөгөөд иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дараагийн хуралдаанд бэлтгэх, хуралдааныг товлон зарлах үүрэгтэй. Зөвлөлийн хурлыг өмнөх хуралдааны дарга даргална.

33.9.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг тухайн хуралдаанаас сонгогдсон дарга удирдан явуулна.

33.10.Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны даргад ажилласан хугацааны урамшууллыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс олгож болно.

33.11.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны даргыг улируулан сонгож болно.

34 дүгээр зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

34.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг нутгийн өөрөө удирдах байгууллага мөн.

34.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

35 дугаар зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль

35.1.Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгчийг тухайн орон нутагт байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгоно.

35.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас сонгож байгуулна.

Тайлбар: Энэ хэсгийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн мөрдөнө.

35.3.Сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгуульд улс төрийн нам нэр дэвшүүлж оролцохгүй.

35.4.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.

36 дугаар зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

36.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.1.1.Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийн тухай асуудал;

36.1.2.Хурлын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах;

36.1.3.тухайн Хурлын хороог байгуулах, хорооны бүрэлдэхүүн, даргыг сонгох, өөрчлөх;

36.1.4.тухайн шатны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх;

36.1.5.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

36.1.6.тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөх;

36.1.7.хуульд заасан үндэслэлээр тухайн шатны Засаг даргыг огцруулах талаар дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайдад санал тавих;

36.1.8.нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;

36.1.9.Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах;

36.1.10.хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;

36.1.11.орон нутгийн өмчийн зүйлсийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;

36.1.12.орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;

36.1.13.энэ хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

36.1.14.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;

36.1.15.хуульд заасан бусад бүрэн эрх.

36.2.Энэ хуулийн 37 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ асуудлыг шийдвэрлэхэд оролцохыг хориглоно.

37 дугаар зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэн эрхийнхээ зарим асуудлыг шилжүүлэх

37.1.Бүрэн эрхийнхээ зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд; сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал багийн иргэдийн Нийтийн Хуралд; нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд; дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хорооны иргэдийн Нийтийн Хуралд тус тус шилжүүлж болно. Ийнхүү шилжүүлэхдээ тухайн асуудлыг шийдвэрлэхэд баримтлах зарчмыг тодорхойлж болно.

38 дугаар зүйл.Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох

38.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хугацаа дараах тохиолдолд хугацаанаас өмнө дуусгавар болно:

38.1.1.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчдийн олонх нь тухайн Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж санал оруулсан бол Хурлын нийт төлөөлөгчийн гуравны хоёроос доошгүйн саналаар тухайн Хурал өөрөө тарах шийдвэр гаргана;

38.1.2.ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 50 хоногийн дотор анхдугаар хуралдаан хуралдуулж Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэж чадаагүй, хуульд заасан хугацаанд төсвөө батлаагүй, түүнчлэн хуралдаан зарлаж товчлон хугацаанаас хойш хуралдахгүй 60-аас дээш хоног өнгөрсөн бол тухайн Хурлыг аймаг, нийслэлийн Засаг даргын санал оруулснаар Засгийн газар тараана.

38.2.Хурлын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд сонгуулийг 30 хоногийн дотор холбогдох хуульд заасны дагуу товчлон зарлана.

39 дүгээр зүйл.Хурлын төлөөлөгчдийн тоо

39.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоог доор дурдсанаар тогтооно:

- 39.1.1.аймгийн хүн амын тоо нь 50000 хүртэл бол 25;
- 39.1.2.аймгийн хүн амын тоо нь 50001-70000 хүртэл бол 29;
- 39.1.3.аймгийн хүн амын тоо нь 70001-90000 хүртэл бол 35;
- 39.1.4.аймгийн хүн амын тоо нь 90001-ээс дээш бол 41.

39.2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоог доор дурдсанаар тогтооно:

- 39.2.1.сумын хүн амын тоо нь 2000 хүртэл бол 15;
- 39.2.2.сумын хүн амын тоо нь 2001-5000 хүртэл бол 21;
- 39.2.3.сумын хүн амын тоо нь 5001-9000 хүртэл бол 25;
- 39.2.4.сумын хүн амын тоо нь 9001 ба түүнээс дээш бол 29.

39.3.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоо 45 байна.

39.4.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоог доор дурдсанаар тогтооно:

- 39.4.1.дүүргийн хүн амын тоо нь 100000 хүртэл бол 25;
- 39.4.2.дүүргийн хүн амын тоо нь 100001-200000 хүртэл бол 35;
- 39.4.3.дүүргийн хүн амын тоо нь 200001-300000 хүртэл бол 41;
- 39.4.4.дүүргийн хүн амын тоо нь 300001 ба түүнээс дээш бол 43.

40 дүгээр зүйл.Хурлын төлөөлөгч

40.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь улс төр, өөрийн болон өөрт хамаарал бүхий этгээдийн эрх, ашиг сонирхлыг илэрхийлэхгүй бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлагч мөн.

40.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

40.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоол батлагдсанаар эхэлж, шинээр сонгогдсон төлөөлөгчийн бүрэн эрх эхэлснээр дуусгавар болно.

40.4.Нөхөн сонгогдсон Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

40.5.Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгч нь үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн дүрэмтэй байх бөгөөд ёс зүйн дүрмийг Хурал батална.

40.6.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно.

41 дүгээр зүйл.Хурлын төлөөлөгчийн эрх, үүрэг

41.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч дараах эрх, үүрэгтэй байна:

- 41.1.1.асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;
- 41.1.2.Хурлын хороонд харьяалагдах;
- 41.1.3.хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж хариулт авах, санал дүгнэлт гаргах,

санал хураалгах;

- 41.1.4.Хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах;

41.1.5.Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсголыг хэлэлцэх санал гаргах;

41.1.6.Хурлын шийдвэрийг сонгогчиддоо тайлбарлан таниулах;

41.1.7.Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг даргад асуулт, асуулга тавих;

41.1.8.сонгогчидтой тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах;

41.1.9.үйл ажиллагаагаа жилд нэг удаа сонгогчиддоо тайлагнах.

41.2.Хурлын төлөөлөгч эрх, үүргээ хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохоос татгалзана.

41.3.Хурлын төлөөлөгчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд улс төрийн нам, бусад байгууллага, албан тушаалтан оролцох, нөлөөлөхийг хориглоно.

41.4.Хурлын төлөөлөгч нь хуралдааны чөлөөт цагт Хурлын хорооны үйл ажиллагаанд оролцож, төлөөлөгчийн хувьд хийсэн ажлынхаа талаарх мэдээллийг Хурлын цахим хуудсаар болон бусад хэлбэрээр сонгогчиддоо мэдээлнэ.

42 дугаар зүйл.Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

42.1.Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

42.1.1.энэ хуульд өөрөөр заагаагүй бол Засаг даргын харьяа болон үйл ажиллагаагаа хариуцан тайлагнадаг, түүнээс санхүүжилт авдаг аливаа байгууллага, бүтцийн нэгжид удирдах ажил, албан тушаал эрхлэх;

42.1.2.төлөөлөгчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулах, хувьдаа ашиглах.

43 дугаар зүйл.Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болох

43.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх дараах үндэслэлээр хугацаанаас өмнө дуусгавар болно:

43.1.1.нас барсан;

43.1.2.хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;

43.1.3.гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан;

43.1.4.тухайн орон нутгаас шилжсэн;

43.1.5.энэ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон;

43.1.6.энэ хуулийн 42.1 дэх хэсгийг зөрчсөн;

43.1.7.Хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн;

43.1.8.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болох үндэслэлтэй болохыг тогтоосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон.

43.2.Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 43.1.2, 43.1.4, 43.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 43.1.3, 43.1.6, 43.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

44 дүгээр зүйл.Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах

44.1.Төлөөлөгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа гэсэн үндэслэлээр тухайн тойргийн сонгогчдын олонхын саналаар төлөөлөгчийг эгүүлэн татна.

44.2.Сонгогчдын саналаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг эгүүлэн татах журмыг Улсын Их Хурал батална.

45 дүгээр зүйл.Хурлын төлөөлөгчид хүлээлгэх хариуцлага

45.1.Хурлын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй, хурлын дэг зөрчсөн, эсхүл үйл ажиллагаагаа хуульд заасны дагуу тайлагнаагүй бол Хурлаас доор дурдсан хариуцлагыг хүлээлгэнэ:

45.1.1.сануулах;

45.1.2.хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух, үг хэлэх эрхийг тухайн хуралдааны хугацаанд хасах;

45.1.3.санал хураалтаас бусад үйл ажиллагаанд оролцох эрхийг тухайн хуралдааны явцад хасах;

45.1.4.асуудал оруулах эрхийг тухайн хуралдааны явцад хасах.

46 дугаар зүйл.Төлөөлөгчийн үйл ажиллагааны баталгаа

46.1.Хурлын төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

46.2.Хурлын төсөвт төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тусгана. Зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална.

46.3.Хурлын төлөөлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

46.4.Улс төрийн нам, улс төрийн бусад байгууллага төлөөлөгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, үүрэг хүлээлгэхийг хориглоно.

47 дугаар зүйл.Хурлын хороо

47.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий төсвийн болон Хурлын хороо байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангана.

47.2.Хороог Хурлын бүрэн эрхийн хугацаагаар төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд Хорооны даргыг тухайн хорооны төлөөлөгчдийн дотроос сонгоно.

47.3.Хороо тухайн Хуралд ажлаа хариуцан тайлагнана.

47.4.Хурал нь судалгаа, санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий Хурлын хороо, ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.

47.5.Хорооны үйл ажиллагааны чиглэл, тоо, бүрэлдэхүүн, түүнчлэн Хороо, ажлын хэсэг байгуулах, хороог татан буулгах, тэдгээрийн ажиллах журмыг Хурал өөрөө тогтооно.

47.6.Улс төрийн нам, эвсэл иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр нэгж байгуулахгүй.

48 дугаар зүйл.Хурлын хуралдаан

48.1.Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна:

48.1.1.иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулна;

48.1.2.аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдааныг нийт төлөөлөгчдийн гуравны нэгээс доошгүйн саналаар эсхүл Хурлын Зөвлөл, Хурлын даргын санаачлагаар хуралдуулна;

48.1.3.иргэдийн Нийтийн Хурлын ээлжит бус хуралдааныг Хурлын Зөвлөл, Засаг даргын санаачлагаар, эсхүл баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэдийн арваас доошгүй хувь нь санал болгосноор хуралдуулна. Иргэд саналаа гарын үсэг зурах хэлбэрээр илэрхийлнэ;

48.1.4.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааныг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 20 хоногийн дотор, бусад хуралдааныг тухайн Хурлын дарга хуралдаан эхлэхээс 7-гоос доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна;

48.1.5.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааныг шинээр сонгогдсон төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад нь, бусад хуралдааныг Хурлын дарга, түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор төлөөлөгчдийн аль нэг нь удирдана;

48.1.6.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тухайн Хурлын нийт төлөөлөгчийн олонх нь хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно;

48.1.7.хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар Хурлын төлөөлөгч хуралдаанд оролцохгүй байх, түүнийг орхиж гарахыг хориглоно;

48.1.8.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг тухайн Хурал өөрөө тогтоож тогтоолоор батална.

49 дүгээр зүйл.Хуралд асуудал оруулах эрх

49.1.Хурлын хороо, түүнчлэн төлөөлөгч, тухайн нэгжийн Засаг дарга асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй.

49.2.Энэ хуулийн 49.1-д заасан саналд холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж хуралдаан болохоос ажлын хоёр хоногийн өмнө Хурлын төлөөлөгчдөд тараах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.

50 дугаар зүйл.Хурлын шийдвэр

50.1.Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн болон баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхын саналаар тус тус батална.

50.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолд Хурлын дарга, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын тогтоолд хуралдааны дарга, Хурлын даргыг сонгох, чөлөөлөх тухай тогтоолд тухайн хуралдааныг даргалагч тус тус гарын үсэг зурна.

50.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хурлын дарга захирамж гаргана.

51 дүгээр зүйл.Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх

51.1.Бүх шатны Засаг дарга тухайн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

51.2.Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхээс өмнө энэ хуулийн 52 дугаар зүйлд зааснаар тухайн шийдвэрт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

51.3.Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг Тамгын газар, нутгийн захиргааны агентлагийг оролцуулан зохион байгуулна.

51.4.Засаг дарга Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаар жил бүр тухайн Хуралд тайлагнана.

52 дугаар зүйл.Хурлын шийдвэрт хориг тавих

52.1.Тухайн Хурал Үндсэн хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн, төрийн бодлоготой зөрчилдсөн, өөрийнх нь бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжих санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга өөрийн санаачилгаар, эсхүл дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдын даалгаснаар холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй.

52.2.Хоригийг тухайн шийдвэр батлагдсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан бичгээр тавих бөгөөд хориг тавих болсон үндэслэлийг тодорхой заана.

52.3.Хурал хоригийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор хуралдаанаар хэлэлцэх бөгөөд түүнийг нийт төлөөлөгчийн олонх нь хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн шийдвэр, тэдгээрийн холбогдох хэсгийн заалт хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

52.4.Хурлын шийдвэрт бүхэлд нь хориг тавьсан бол үйлчлэлийг бүрэн хэмжээгээр, хэсэгчлэн хориг тавьсан бол холбогдох зүйл, заалтын үйлчлэлийг уг шийдвэрийг Хурлын дарга хүлээн авснаас хойш хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд түдгэлзсэнд тооцно.

52.5.Засаг даргыг огцруулах асуудлаар санал гаргасан тухайн Хурлын шийдвэрт Засаг дарга хориг тавих эрхгүй.

52.6.Тавьсан хоригийг нь Хурал өөрийн төлөөлөгчдийн эсхүл иргэдийн олонхын саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно.

53 дугаар зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл

53.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, дараагийн хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий 5 хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.

53.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.

53.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны төгсгөлд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийг шинээр байгуулна.

53.4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурал батална.

54 дүгээр зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын бүрэн эрх

54.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

54.1.1.тухайн Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг хангах;

54.1.2. тухайн Хурлын хуралдааныг даргалах, гарсан шийдвэрийг ёсчилж баталгаажуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

54.1.3. хороо, төлөөлөгчид бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангах ажлыг зохион байгуулалтын удирдлагаар хангах;

54.1.4. эрх бүхий этгээдээс Хурлаар хэлэлцүүлэхээр тавьсан саналыг хүлээн авах, гарах шийдвэрийн төслийг боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

54.1.5. Хурлын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах ажлыг зохион байгуулах;

54.1.6. Хурлын нарийн бичгийн даргыг хуульд заасан журмын дагуу томилох, чөлөөлөх асуудлыг Хуралд оруулж шийдвэрлүүлэх;

54.1.7. Хурлын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;

54.1.8. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

54.1.9. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн Хуралд ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

54.1.10. тухайн Хурлыг дотоод, гадаадад төлөөлөх;

54.1.11. жил бүр Хуралд ажлаа тайлагнах;

54.1.12. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

55 дугаар зүйл. Хурлын даргыг сонгох

55.1. Сонгуулийн дүнгээр байгуулагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанаар Хурлын даргыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

55.2. Тухайн хуралдаанд оролцсон хамгийн ахмад настай төлөөлөгч Хурлын даргад эхэлж нэр дэвшүүлнэ.

55.3. Тухайн Хурлын төлөөлөгчид Хурлын даргад өөрийн болон бусад төлөөлөгчийн нэрийг дэвшүүлж болно.

55.4. Хурлын даргыг сонгох асуудлаар нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхын саналаар сонгоно.

55.5. Энэ хуулийн 55.4-д заасан санал хураалтаар нэр дэвшигчдийн аль нь ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг хоёр дахь санал хураалтад оруулах бөгөөд тэдгээрийн хэн нь ч олонхын санал аваагүй бол энэ зүйлд заасан журмаар Хурлын даргад дахин нэр дэвшүүлнэ.

55.6. Хурлын төлөөлөгчид санал хураалтад оролцоходоо зөвхөн нэг хүний төлөө санал өгөх бөгөөд нэр дэвшигч өөрөө санал хураалтад оролцох эрхтэй.

55.7. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга орон тооны байна.

56 дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба

56.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ажлын албатай байна.

56.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно.

56.3. Ажлын албаны дарга нь тухайн Хурлын нарийн бичгийн дарга байх бөгөөд орон тооны байна.

56.4.Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хурлын нарийн бичгийн дарга тушаал гаргана.

57 дугаар зүйл.Хурлын төсөв, тамга, тэмдэг

57.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтэй байх бөгөөд төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна.

57.2.Энэ хуулийн 57.1-д заасан төсөв нь Хурлын үйл ажиллагааны болон ажлын албаны төсвөөс бүрдэнэ.

57.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

**Гуравдугаар дэд бүлэг
Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх
төрийн удирдлага**

58 дугаар зүйл.Засаг дарга, түүнийг томилох

58.1.Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, мөн түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн.

58.2.Засаг даргыг томилуулахаар тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурал нэр дэвшүүлнэ.

58.3.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргад нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

58.3.1.дээд боловсролтой;

58.3.2.төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан;

58.3.3.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;

58.3.4.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх;

58.3.5.ялгүй байх.

58.4.Баг, хорооны Засаг даргад нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

58.4.1.дээд боловсролтой;

58.4.2.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;

58.4.3.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх;

58.4.4.ялгүй байх.

58.5.Засаг даргад дараах журмаар нэр дэвшүүлнэ:

58.5.1.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, иргэдийн Нийтийн Хуралд оролцогч дангаараа буюу хамтарч, түүнчлэн дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд нэр дэвшүүлэх санал гаргаж болно;

58.5.2.санал болгосон хүний талаар санал хураалт явуулж, хуралд оролцсон иргэдийн,

түүнчлэн нийт төлөөлөгчдийн олонхын санал авсан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлнэ;

58.5.3.хэрэв санал хураалтаар хэн ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүний талаар дахин санал хурааж олонхын санал авсан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлнэ.

58.5.4.Нэр дэвшигч нь энэ хуульд заасан шаардлагыг хангасан байна.

58.6.Энэ зүйлийн 58.5-д заасны дагуу нэр дэвшүүлсэн хүнийг баг, хорооны Засаг даргаар сум, дүүргийн Засаг дарга; сум, дүүргийн Засаг даргаар аймаг, нийслэлийн Засаг дарга; аймаг, нийслэлийн Засаг даргаар Ерөнхий сайд тус тус томилно.

58.7.Дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд тухайн нэр дэвшигчийг томилохоос татгалзаж болно.

58.8.Энэ зүйлийн 58.7-д зааснаар томилохоос татгалзсан тохиолдолд иргэдийн Хурал энэ зүйлийн 58.5-д заасан журмаар өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

58.9.Энэ хуулийн 58.8-д заасан журмаар нэр дэвшүүлсэн хүнийг ажлын 5 хоногийн дотор тухайн шатны Засаг даргаар томилно.

59 дүгээр зүйл.Засаг даргын бүрэн эрхийн хугацаа

59.1.Засаг даргын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

59.2.Энэ хуулийн 59.1-д заасан хугацаа нөхөн томилогдсон Засаг даргад хамаарахгүй.

60 дугаар зүйл.Багийн Засаг даргын бүрэн эрх

60.1.Багийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

60.1.1.хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах;

60.1.2.багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх;

60.1.3.энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан асуудлаар Хурлаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;

60.1.4.сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд нь сургуульд оруулах, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авах;

60.1.5.шаардлагатай иргэдийг асрамжийн болон халамжийн үйлчилгээнд хамруулах саналыг хууль тогтоомжийн дагуу сумын Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;

60.1.6.нутаг дэвсгэрийн хүн амын амьжиргааны түвшинг судалж, хууль тогтоомжид заасан хүрээнд нийгмийн халамж, үйлчилгээ зохион байгуулах;

60.1.7.гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед айл өрх, хүн, малыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийг зохих үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулах, хуульд заасан тохиолдолд хүн хүч, тээвэр, холбооны хэрэгсэл, эд хөрөнгийг дайчлах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;

60.1.8.хүн ам, өрхийн болон иргэний түр оршин суух бүртгэлийг зохих журмын дагуу бүртгэх;

60.1.9.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих;

60.1.10.байгалийн баялгийг ашиглах, тогтоомжийн биелэлтэд олгогдсон эрх хэмжээний хүрээнд хяналт тавих;

60.1.11.гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

60.1.12.иргэнийг шагнаж урамшуулах, иргэнд дэмжлэг, тусламж үзүүлэх тухай саналыг сумын Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх.

61 дүгээр зүйл.Сумын Засаг даргын бүрэн эрх

61.1.Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

61.1.1.хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах;

61.1.2.энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;

61.1.3.сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

61.1.4.сумын төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

61.1.5.сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;

61.1.6.сумын өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, сумын өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэргээр захиран зарцуулах санал боловсруулж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлэх;

61.1.7.хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;

61.1.8.аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;

61.1.9.энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д заасан асуудлаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо, үндэслэл бүхий саналыг сумын иргэдийн төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх;

61.1.10.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чиглэлээр холбогдох хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

61.1.11.хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах;

61.1.12.байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх;

61.1.13.нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, бэлчээр, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

61.1.14.Хурлын шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн тусгай хэрэгцээний газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах тухай шийдвэр гаргах;

61.1.15.сумын Засаг даргын олгосон газар эзэмших, ашиглах эрхийн талаарх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хооронд үүссэн маргааныг Газрын тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх;

61.1.16.хуульд заасан зориулалтаар эдэлбэр газар олгох;

61.1.17.нутаг дэвсгэрийнхээ байгалийн баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, эзэмших тухай иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн талаар гаргасан сумын Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

61.1.18.нутаг дэвсгэрт нь газар ашиглах, эзэмших, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах;

61.1.19.нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

61.1.20.хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллагууд эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж байгаа эсэхэд тэдгээрийн харъяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хяналт тавих;

61.1.21.гамшиг, осол, аюулт үзэгдлийн үед эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, гамшигийн хор уршгийг арилгахтай холбогдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу түүний тодорхой хэсэгт түр хугацаанд дагаж мөрдөх журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, хүн хүч дайчлах, төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тээвэр, холбооны хэрэгсэл, хүнс тэжээлийн нөөцийг дайчлах;

61.1.22.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

62 дугаар зүйл.Аймгийн Засаг даргын бүрэн эрх

62.1.Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

62.1.1.хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах;

62.1.2.аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх;

62.1.3.аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

62.1.4.аймгийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

62.1.5.аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;

62.1.6.аймгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, аймгийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлэх;

62.1.7.аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;

62.1.8.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан гэрээний дагуу энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;

62.1.9.хууль тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг хариуцах;

62.1.10.энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д заасан асуудлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо, үндэслэл бүхий саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх;

62.1.11.хууль тогтоомжид заасан журмын дагуу гадаад улсын зохих шатны нэгжтэй харилцаж, хамтран ажиллах;

62.1.12.нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

62.1.13.газар эзэмших, ашиглахтай холбогдсон маргааныг Газрын тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх;

62.1.14.газар нутгийнхаа тодорхой хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах санал боловсруулж Хуралд оруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

62.1.15.гамшиг, осол, аюулт үзэгдлийн үед эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу түүний тодорхой хэсэгт түр хугацаанд дагаж мөрдөх журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, хүн хүч дайчлах, төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тээвэр, холбооны хэрэгсэл, хүнс тэжээлийн нөөцийг дайчлах;

62.1.16.дотоод, гадаадад тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх;

62.1.17.тухайн нутаг дэвсгэр дэх шүүх, прокурорын байгууллагад шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

62.1.18.аймгийн хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авах;

62.1.19.сумдын үйл ажиллагаа төрийн бодлого, хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

62.1.20.аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг тараах саналыг Засгийн газарт оруулах;

62.1.21.төрийн дээд шагналд тодорхойлох;

62.1.22.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

63 дугаар зүйл.Хорооны Засаг даргын бүрэн эрх

63.1.Хорооны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

63.1.1.хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах;

63.1.2.хорооны иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх;

63.1.3.энэ хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д заасан хорооны эдийн засаг нийгмийн амьдралын тодорхой асуудлаар хорооны иргэдийн саналыг авах арга хэмжээг зохион байгуулах, дүнг нэгтгэн гаргах;

63.1.4.энэ хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3, 26.1.6-д заасан асуудлаар хорооны иргэдийн Нийтийн Хурлаас гаргах шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо, судалгаа, саналаа иргэдийн Нийтийн Хуралд оруулан шийдвэрлүүлэх;

63.1.5.энэ хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.5-д заасан асуудлаар иргэдийн Нийтийн Хурлаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд хорооны иргэдийн оролцуулах арга хэмжээг зохион байгуулах;

63.1.6.улс, нийслэл, дүүргийн чанартай асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хорооны хүн амыг зохион байгуулж оролцуулах;

63.1.7.төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын болон дээд шатны Засаг даргын шийдвэр, хорооны иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг сурталчлах;

63.1.8.байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлага тавих, биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;

63.1.9.нутаг дэвсгэрийн хүн амын амьжиргааны түвшинг судалж, хууль тогтоомжид заасан хүрээнд нийгмийн халамж, үйлчилгээг зохион байгуулах;

63.1.10.хүн амын хүнс, худалдаа, үйлчилгээ, цахилгаан, дулаан хангамжийн зохион байгуулалт, хүртээмжид хяналт тавьж, түүнийг сайжруулах талаар иргэдээс гарсан санал, хүсэлтийг холбогдох байгууллагад уламжлах;

63.1.11.сургуулийн өмнөх насны хүүхдийг бүртгэж тухайн жилд сургуульд элсүүлэх, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулах арга хэмжээ авах;

63.1.12.гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед айл өрх, хүн, малыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийг зохих үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжид заасан тохиолдолд хүн хүч, тээвэр, холбооны хэрэгсэл, эд хөрөнгийг дайчлах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;

63.1.13.хууль тогтоомжид заасны дагуу статистикийн мэдээллийг гаргах;

63.1.14.хууль тогтоомжид заасны дагуу иргэний бүртгэл, мэдээллийн ажлыг зохион байгуулах, цэргийн бүртгэлийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

63.1.15.иргэдийн өргөдөл, санал, гомдлыг хүлээн авч эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжлах;

63.1.16.иргэнийг шагнаж урамшуулах, иргэнд дэмжлэг, тусламж үзүүлэх асуудлыг дүүргийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;

63.1.17.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих;

63.1.18.нутаг дэвсгэрийнхээ хэмжээний газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хуульд заасан чиг үүргийн дагуу оролцох;

63.1.19.дүүргийн төсөв боловсруулахад хорооны нийгмийн хөгжлийн асуудлаар санал гаргах;

63.1.20.харьяалах хэсгийн ахлагч нарыг томилж, үйл ажиллагааг нь удирдах;

63.1.21.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

64 дүгээр зүйл. Дүүргийн Засаг даргын бүрэн эрх

64.1. Дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

64.1.1. хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах;

64.1.2. дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх;

64.1.3. дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулж дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

64.1.4. дүүргийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

64.1.5. дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;

64.1.6. дүүргийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, дүүргийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулж дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлэх;

64.1.7. хууль тогтоомж болон дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;

64.1.8. нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;

64.1.9. энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д заасан асуудлаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо, үндэслэл бүхий саналыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх;

64.1.10. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чиглэлээр холбогдох хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

64.1.11. дүүргийн татварын албаны үйл ажиллагааг удирдан чиглүүлж, татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

64.1.12. дүүргийн Засаг даргаас олгосон газар эзэмших, ашиглах эрхийн талаарх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

64.1.13. дүүргийн Засаг даргын орлогч, Тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, огцруулах;

64.1.14. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

65 дугаар зүйл. Нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

65.1. Нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

65.1.1. хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах;

65.1.2.нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх;

65.1.3.нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулж нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

65.1.4.нийслэлийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

65.1.5.нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;

65.1.6.нийслэлийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, нийслэлийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулж нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлэх;

65.1.7.нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;

65.1.8.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан гэрээний дагуу энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;

65.1.9.хууль тогтоомж болон нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг хариуцах;

65.1.10.энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д заасан асуудлаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо, үндэслэл бүхий саналыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх;

65.1.11.хууль тогтоомжид заасан журмын дагуу гадаад улсын зохих шатны нэгжтэй харилцаж, хамтран ажиллах;

65.1.12.нийслэлийн татварын албаны үйл ажиллагааг удирдан чиглүүлж, татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

65.1.13.нийслэлийн Засаг даргаас олгосон газар эзэмших, ашиглах эрхийн талаарх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

65.1.14.нийслэлийн Засаг даргын орлогч, Тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх, огцруулах;

65.1.15.нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг тараах саналыг Засгийн газарт оруулах;

65.1.16.төрийн дээд шагналд тодорхойлох;

65.1.17.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

66 дугаар зүйл.Засаг даргыг чөлөөлөх, огцруулах, Засаг дарга огцрох

66.1.Аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хорооны Засаг дарга эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлт гаргасан бол дээд шатны Засаг дарга буюу Ерөнхий сайд түүнийг бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлнө.

66.2.Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд дараах тохиолдолд доод шатны Засаг даргыг огцруулна:

66.2.1.Засаг дарга гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор нотлогдсон;

66.2.2.хууль тогтоомж удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн;

66.2.3.энэ хуулийн 67.1.1, 67.1.2-т заасан үндэслэлээр Хурал дүгнэж санал гаргасан;

66.2.4.Засаг дарга өөрөө огцрох хүсэлтээ гаргасан;

66.2.5.энэ хуулийн 67.1.3-т заасан үндэслэлээр.

66.3.Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 66.2-д заасан үндэслэлээр зохих шатны Хурлын санал, эсхүл өөрийн санаачлагаар Засаг даргыг огцруулах шийдвэр гаргана. Энэхүү шийдвэрээ тухайн Хуралд Засаг даргыг нэн даруй мэдэгдэх бөгөөд Хурал 15 хоногийн дотор Засаг даргад шинээр нэр дэвшүүлнэ.

66.4.Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 66.2.3-т заасныг баримтлан гаргасан тухайн Хурлын саналыг үндэслэн Засаг даргыг огцруулах шийдвэрийг 14 хоногийн дотор гаргана. Хэрэв уг саналыг хүлээж аваагүй бол Хурал Засаг даргыг огцруулах саналыг нэг жилийн хугацаанд дахин тавихгүй.

66.6.Засаг даргыг хугацаанаас нь өмнө чөлөөлсөн, огцруулсан бол Засаг даргыг шинээр томилох хүртэлх хугацаанд түүний бүрэн эрхийг нь Засаг даргын орлогч хэрэгжүүлж хариуцлагыг бүрэн хүлээнэ.

67 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргад хариуцлага тооцох

67.1.Засаг даргад дараах үндэслэлээр хариуцлага тооцно:

67.1.1.Хурлын шийдвэрийн биелэлтийг хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн;

67.1.2.Нутаг дэвсгэрийнхээ нийгэм, эдийн засаг, хүн амын амьдралын асуудалтай холбогдох хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж тухайн Хурал дүгнэсэн;

67.1.3.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон Ерөнхий сайд, дээд шатны Засаг даргын өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн гэж дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд үзсэн.

67.2.Энэ зүйлийн 67.1.1, 67.1.2-д заасан үндэслэл бүрдсэн гэж Хурлын төлөөлөгчдийн гуравны нэгээс доошгүй нь үзэж гарын үсэг зурсан бол Хурал 15 хоногийн дотор уг саналыг хуралдаанаараа хэлэлцэж нийт төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

67.3.Ерөнхий сайд, дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргад энэ хуулийн 67.1-д заасныг баримтлан тухайн шатны Хурлын санал эсхүл өөрийн санаачилгаар дараах сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна:

67.3.1.сануулах;

67.3.2.үндсэн цалинг 20 хүртэлх хувиар 3 сар хүртэлх хугацаагаар хасах.

67.4.Энэхүү хуулийн 67.3-т заасны дагуу ногдуулсан хариуцлагыг шат дараалан хэрэглэнэ.

68 дугаар зүйл. Засаг даргын шийдвэр

68.1.Засаг дарга энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.

68.2.Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтээр дагаж мөрдөх, хэм хэмжээ тогтоосон акт гаргасан бол Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу бүртгүүлнэ.

68.3.Засаг даргын захирамж хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд хүчингүй болгоно.

69 дүгээр зүйл. Засаг даргын ажлын алба

69.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

69.1.1. харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах;

69.1.2. Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;

69.1.3. Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;

69.1.4. хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;

69.1.5. Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

69.1.6. төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

69.1.7. тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг хангаж аж ахуйн талаар үйлчлэх;

69.1.8. татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээллийг гаргаж өгөх;

69.1.9. Хувь хүний орлогын албан татвар, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Малын тоо толгойн албан татварын тухай хууль болон бусад хуульд заасан албан татвар, төлбөр, хураамжийг хураах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах.

69.2. Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хэлтэс, тасагтай байна.

69.3. Тамгын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, Засаг дарга 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.

69.4. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Тамгын газрын дарга Засгийн газраас тогтоосон бүтэц, орон тооны хязгаарт багтаан Тамгын газрын орон тоо, цалингийн санг тогтоож, ажилтнуудыг томилж, чөлөөлнө.

69.5. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН УДИРДЛАГЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ХОТ, ТОСГОНД ШИЛЖҮҮЛЭХ

70 дугаар зүйл. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх

70.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, дэд бүтэц, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

70.2. Хот, тосгонд шилжүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт олгох үүргийг төр хүлээнэ.

70.3. Хотын зэрэглэл тосгоны онцлогийг харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлж болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хязгаарлалт тогтоож болно.

71 дүгээр зүйл. Хот, тосгонд шилжүүлэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэг

71.1. Улсын зэрэглэлтэй хот, түүний үндсэн нэгжид энэ хуулийн 21-23 дугаар зүйлд заасан аймаг, сум, багийн зарим чиг үүргийг шилжүүлнэ.

71.2. Орон нутгийн зэрэглэлтэй хот, түүний үндсэн нэгжид энэ хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан сум, багийн зарим чиг үүргийг шилжүүлнэ.

71.3. Тосгонд энэ хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан сум, багийн хэрэгжүүлэхээр заасан зарим чиг үүргийг шилжүүлнэ.

71.4. Хууль тогтоомжид тусгайлан заавал энэ зүйлд зааснаас өөрөөр чиг үүргийг нэг бүрчлэн хот, тосгонд олгож болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

НЭГЖИЙН УДИРДЛАГА БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ

72 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засгийн газар, яам агентлагтай харилцах

72.1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хууль, бусад хууль тогтоомжоор өөрт нь ногдуулсан, орон нутгийн шинжтэй асуудлыг шийдвэрлэхдээ улсын ашиг сонирхлыг харгалзаж, бодлого, шийдвэрээ төрийн бодлоготой уялдуулна.

72.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төрөөс шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлсэн талаар Засгийн газар, холбогдох яам, агентлагийг мэдээллээр хангаж, хууль гэрээгээр заасан хугацаанд тайлагнана.

73 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газартай харилцах

73.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газартай доор дурдсан журмаар харилцана:

73.1.1. жил бүр үйл ажиллагааныхаа тайланг Засгийн газарт хүргүүлэх бөгөөд Засгийн газар уг тайланг хуралдаанаараа хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөх;

73.1.2. нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулж тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх, эс дэмжвэл өөрийн саналыг Ерөнхий сайдад уламжлах;

73.1.3. нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг хэлэлцэхэд Засгийн газрын хуралдаанд оролцож санал, байр сууриа илэрхийлэх.

74 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг дарга яам, агентлагтай харилцах

74.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга яам, агентлагтай доор дурдсан журмаар харилцана:

74.1.1. төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа яам, агентлагтай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах;

74.1.2. харьяалах нутаг дэвсгэрийн салбарын болон салбар хоорондын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхдээ хамтарсан шийдвэр гаргаж биелэлтийг зохион байгуулах;

74.1.3. нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн асуудлаар яамтай хамтран хэрэгжүүлэх нэгдсэн бодлогын талаар Ерөнхий сайдтай шууд харилцах;

74.1.4. орон нутгийн хүч, хөрөнгөөр шийдвэрлэх боломжгүй нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагад саналаа уламжлах;

74.1.5. эдийн засаг, нийгмийн хөгжил, хот байгуулалт, хүрээлэн буй орчныг хамгаалах, төрөөс хүн амд үзүүлэх үйлчилгээтэй холбогдсон асуудлаар яам, агентлагт санал тавьж шийдвэрлүүлэх.

74.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга ба яам, агентлагийн хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Засгийн газар шийдвэрлэнэ.

74.3. Орон нутгийн хөгжил, засаг захиргааны шинэтгэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын бүтцэд байна.

75 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын хамтын ажиллагаа

75.1. Хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо хоорондоо нийтийн эрх зүйн гэрээ байгуулж болно.

75.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааны явцад аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол харьяалах дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд тус тус шийдвэрлэнэ.

76 дугаар зүйл. Засаг дарга иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах

76.1. Засаг дарга өөрөө эсхүл эрх бүхий байгууллагаар дамжуулан харьяа нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжийг биелүүлэх талаар үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь шалгаж болно.

76.2. Засаг дарга хууль тогтоомжийг биелүүлэх зорилгоор харьяа нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагатай нийтийн эрх зүйн гэрээ байгуулж болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД

77 дугаар зүйл.Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааг хуулиар тусгайлан зохицуулах

77.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нэгжийн газар зүйн байршил, хүн амын тоо, суурьшил, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, хил хамгаалалт, улсын эдийн засагт үзүүлэх нөлөө зэрэг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тусгайлан зохицуулж болно.

77.2.Үндэсний болон бүс нутаг, олон улсын эдийн засаг, байгалийн тэнцэл, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө зэрэг нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тодорхой онцлогийг илэрхийлэх нөхцөл болно.

77.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн зохицуулах хуулийг зөвхөн Засгийн газар санаачилна.

78 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын шийдвэрийг биелүүлэх

78.1.Хурал, Засаг даргаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ.

78.2.Хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай этгээд бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.

79 дүгээр зүйл.Нэгжийн удирдлагын нийгмийн баталгаа

79.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 6 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.

79.2.Төрийн албанд 25-аас дээш жил ажилласан аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга тэтгэвэр тогтоолгох бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 12 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тусламж олгоно.

80 дугаар зүйл.Нутгийн удирдлагын төлөөлөл

80.1.Нутгийн өөрийн удирдлагын байгууллагуудын нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлэх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, орон нутгийн төсөв боловсруулах, нутгийн удирдлагад чиг үүрэг шилжүүлэх, Засгийн газраас нутгийн удирдлагатай холбоотой асуудлаар шийдвэр гаргах ажиллагаанд төв Засгийн газартай хэлэлцээр хийх, нутгийн удирдлагын байгууллагын өмнөөс шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах чиг үүрэг бүхий нийтийн эрх зүйн этгээдийн эрх эдлэх төлөөллийн байгууллага байна.

80.2.Энэ хуулийн 80.1-д заасан байгууллагад сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус бүрээс нэг төлөөлөгч, аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурал тус бүрээс хоёр төлөөлөгчийг сонгоно.

80.3.Энэ хуулийн 80.1-д заасан байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

81 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

81.1.Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

5 **ДАГАЛДАН ГАРАХ БУСАД ХУУЛЬ, ТОГТООЛЫН ТӨСӨЛ**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙГ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХЭРЭГЖҮҮЛЭХ БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан уг хуулийг дагаж мөрдөх бэлтгэлийг хангах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1/Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан журмуудын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх;

2/Хотын албан татварын тухай болон Малын тоо толгойн албан татварын тухай анхдагч хуулиудын төслийг 2020 онд багтаан боловсруулж, өргөн мэдүүлэх;

3/Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох хуулийн төслийг өргөн мэдүүлэх;

4/Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд захиргааны хэм хэмжээ тогтоосон актуудыг нийцүүлэх;

5/Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтийг сурталчилах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/, Төсвийн байнгын хороо /Б.Чойжилсүрэн/, Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.6.7, 23.8.15, 23.8.16, 23.8.17 дахь заалт нэмсүгэй:

“23.6.7.аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь”

“23.8.15.малын тоо толгойн албан татвар”

“23.8.16.үл хөдлөх хөрөнгийн албан татвар”

“23.8.17.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Өрийн удирдлагын тухай хууль” гэсний дараа “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль” гэж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа, 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “чиг үүргийг” гэсний өмнө, 6 дугаар зүйлийн 6.4.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “болон орон нутгийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.18, 11.1.22 дахь заалтын “орон нутгийн” гэсний өмнө, түүнчлэн 11.1.19 дэх заалтын “Засаг даргын” гэсний өмнө “орон нутгийн саналд үндэслэн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн дараах зүйл, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/“4.1.30.“орон нутгийн төсвийн суурь зарлага” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21, 22, 24, 25 дугаар зүйлд заасан орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлагын нийлбэрийг”

2/“39 дүгээр зүйл. Засгийн газраас чиг үүрэг шилжүүлэх гэрээ

39.1.Энэ хуулийн 14.1.6, 14.1.8-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг даргатай Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан чиг үүргийг орон нутагт шилжүүлэх гэрээ байгуулж болно.

39.2.Энэ хуулийн 39.1-д заасан гэрээг үндэслэн санхүүжилтийг энэ хуулийн 47.1.4-т заасны дагуу холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчаас орон нутагт нэмж олгоно.

39.3.Энэ хуулийн 39.1-д заасан гэрээний биелэлтийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч хагас, бүтэн жилээр дүгнэн, дотоод аудит хийнэ.”

3/“58 дугаар зүйл. Орон нутгийн чиг үүргийг санхүүжүүлэх

58.1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30-д заасан орон нутгийн төсвийн суурь зарлагыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

58.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн татварын болон татварын бус орлого;

58.1.2.улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг;

58.1.3.улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг;

58.2.Орон нутгийн чиг үүрэгтэй холбоотой хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлыг энэ хуулийн 32.2.6, 33.2.6-д заасан жагсаалтад тусгасны үндсэн дээр улсын төсвөөс санхүүжүүлнэ.”

4 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “тусгай зориулалтын шилжүүлэг” гэснийг “санхүүжилт” гэж, 23 дугаар зүйлийн 23.8.14 дэх заалтын “газрын төлбөрийн 40 хувь” гэснийг “газрын төлбөр” гэж, 23.4.1 дэх заалтын “татвар” гэснийг “татварын 60 хувь” гэж, 65 дугаар зүйлийн 65.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1.2 дахь заалтын “байгууллага, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний” гэснийг “байгууллагын” гэж, 65 дугаар зүйлийн 65.1.3 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1.3 дахь заалтын “төлөөлөн хэрэгжүүлэх” гэснийг “шилжүүлэх”, 66 дугаар зүйлийн 66.1.5 дахь заалтын “39.2-т” гэснийг “66.1.3-т” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.2 дахь заалтын “газрын төлбөрийн 60 хувь”, 23.6.3 дахь заалтын “үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар”, 23.6.6 дахь заалтын “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар”, 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь заалтын “үүнээс тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ”, 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсгийн “шилжүүлэг, тусгай зориулалтын” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.4 дэх заалтын дугаарыг “23.6.2” гэж, 23.6.5 дахь заалтын дугаарыг “23.6.3” гэж, 23.6.7 дахь заалтын дугаарыг “23.6.4” гэж, 23.6.8 дахь заалтын дугаарыг “23.6.5” гэж, 23.6.9 дэх заалтын дугаарыг “23.6.6” гэж тус тус өөрчилсүгэй.

7 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.6.5 дахь заалт, 56 дугаар зүйлийн 56.1.3, 56.3.3 дахь заалт, 56.5 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

8 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийн “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэсний дараа “хотын Зөвлөл” гэж, 8.5 дахь хэсгийн “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэсний дараа “улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл” гэж, 8.4 дэх хэсгийн “Хурал” гэсний дараа “орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөл” гэж, 77 дугаар зүйлийн 77.6 дахь хэсгийн “нийслэл” гэсний дараа “хот” гэж, 77.8 дахь хэсгийн “аймаг” гэсний дараа “хот” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.25-д “нийслэл” гэсний дараа “хот” гэж, 77 дугаар зүйлийн 77.7.9-д “нийслэл” гэсний дараа “хот” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.25 дахь заалтын “сумын” гэснийг “сум, тосгоны” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, 46.5 дахь хэсгийн 46.5.1 дэх заалт, 46.9 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.1 дэх заалтын “нийслэлийн” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хотын” гэж, 74 дүгээр зүйлийн 74.2 дахь хэсгийн “дүүргийн” гэснийг “дүүрэг, тосгоны” гэж, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн “нийслэлийн” гэснийг “нийслэл, улсын зэрэглэлтэй хотын” гэж, “сумын” гэснийг “сум, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны” гэж, 77.5 дахь хэсгийн “нийслэл” гэсний дараа “улсын зэрэглэлтэй хот” гэж, “Засаг даргатай” гэснийг “Засаг дарга, хотын Захирагчтай” гэж, 77.8 дахь хэсгийн “сумын” гэснийг “сум, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны” гэж, “Засаг даргатай” гэснийг “Засаг дарга, хот, тосгоны Захирагчтай” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

